



ХОДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ХОДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION



ХОДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН БАРОМЕТРИЙН СУДАЛГАА

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН



**ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**



**ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ**

THE RESEARCH INSTITUTE OF LABOUR AND SOCIAL PROTECTION

***ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН
БАРОМЕТРИЙН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН***

УЛААНБААТАР ХОТ

2019 ОН

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

***ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН
БАРОМЕТРИЙН СУДАЛГАА***

Судалгааг гүйцэтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт,
Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны сектор

Судалгааг гүйцэтгэсэн багийн гишүүд:

М.Алтансүх	ХНХСИ-ийн захирал
Б.Батбаатар	ХНХСИ-ийн дэд захирал
Ч. Цогтбаяр	ХЭБСС-ын эрхлэгч
Г.Мягмардулам	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
Н.Жаргалсайхан	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
Д.Алтангэрэл	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
С.Хүрэл-Эрдэнэ	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
Ш. Дэлгэрхишиг	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан
М. Энхзориг	ХЭБСС-ын эрдэм шинжилгээний ажилтан

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо

Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөрийн ордон, 5 давхар

Утас: 77121286

Вэб хуудас: www.rilsp.gov.mn

АГУУЛГА

АГУУЛГА	III
ӨМНӨХ ҮГ	IV
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	V
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	VI
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	VII
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	VIII
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ	X
БҮЛЭГ 1. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	13
1.1. Хөдөлмөрийн зах зээлийн төлөв	14
1.2. Бүртгэлтэй ажилгүй иргэн	17
1.3. Ажлын байрны захиалга, ажилд зуучлал	18
БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН	26
2.1. Судалгааны ерөнхий мэдээлэл.....	27
2.2. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЭРЭЛТ	42
2.2.1. Оны эхний 6 сарын ажиллах хүчний эрэлт /2020.01-2020.06/.....	43
2.2.2. Оны сүүлийн 6 сарын ажиллах хүчний эрэлт /2020.07-2020.12/.....	43
2.2.3. 2020 оны ажиллах хүчний нийт эрэлт	44
2.3. Ажиллах хүчний хомсдол	58
2.4. Ажил олгогчдод шинэ ажилтан авахад тулгардаг бэрхшээл, мэдээллийн эх сурвалж	62
2.5. Өмнөх судалгааны үр дүнгийн харьцуулалт	63
ДҮГНЭЛТ.....	70
САНАЛ , ЗӨВЛӨМЖ.....	71
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	72
1. Судалгааны танилцуулга.....	73
2. Судалгааны түүвэр, хамрах хүрээ.....	74
3. Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт	76
ХАВСРАЛТ.....	77

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны эрэлтийг тодорхойлох зорилго бүхий барометрийн судалгааг 10 дахь жилдээ гүйцэтгэн, үр дүнг танилцуулж байна. Судалгааны үр дүн нь салбарын бодлогод төдийгүй эрдэмтэн, судлаачид, энэ чиглэлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажилтнуудад ач холбогдол бүхий мэдээлэл болдог билээ.

Энэхүү судалгаа нь олон улсын аргачлалын дагуу хийгддэг бөгөөд хөдөлмөрийн зах зээлийн ирэх нэг жилийн хугацаан дахь ажиллах хүчний эрэлт хэрэгцээг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, бүс нутгаар, ажил мэргэжил бүрээр тодорхойлохын зэрэгцээ өнгөрсөн жилийн ажил мэргэжлийн хомсдолыг мөн дээрх үзүүлэлтүүдээр тодорхойлон гаргадаг болно. Судалгаа нь төрийн удирдлага болон батлан хамгаалахын үйл ажиллагаа, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбаруудаас бусад 18 салбарын хүрээнд хийгдсэнээрээ онцлог юм.

Энэ удаагийн судалгаагаар бид 2020 оны хөдөлмөрийн зах зээлийн ажиллах хүчний эрэлт хэрэгцээ, өнгөрсөн жилийн ажиллах хүчний хомсдолыг тодруулан, тайлагнаж байна.

Та бүхэн судалгааны үр дүнтэй танилцан, өөрсдийн үйл ажиллагаандаа ашиглахын зэрэгцээ судалгааны арга, аргачлалтай холбоотой санал хүсэлтээ бидэнд илгээж, хамтран ажиллахыг хүсье.

ЗАХИРАЛ

М.АЛТАНСҮХ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 0.1. Эрэлттэй ажил мэргэжил, дүнд эзлэх хувиар.....	xii
Хүснэгт 1.1. Ажиллах хүчний зарим статистик үзүүлэлт, бүсээр, мянган хүн	15
Хүснэгт 1.2. Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар	16
Хүснэгт 1.3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар.....	16
Хүснэгт 1.4. Бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, бүсээр, 2019 он.....	18
Хүснэгт 1.5. Ажлын байрны захиалга, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2014-2019 он.....	19
Хүснэгт 1.6. Ажилд зуучлагдсан иргэд, бүсээр, мянган хүн, 2014-2019 он.....	21
Хүснэгт 1.7. Ажилд зуучлагдсан иргэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн, 2014-2019 он.....	21
Хүснэгт 1.8. 2019 онд хөдөлмөр эрхэлж буй гадаад ажиллагчдын хувь, ажил мэргэжлийн үндсэн бүлгээр.....	23
Хүснэгт 1.9. Гадаад ажиллагчид, ажил мэргэжлээр	24
Хүснэгт 1.10. Гадаад ажиллагчдын эзлэх хувь, байгууллагын өмчийн хэлбэрээр	25
Хүснэгт 2.1. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар, үйл ажиллагааны хэлбэрээр	27
Хүснэгт 2.2. Хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт, мян. хүн	29
Хүснэгт 2.3. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар.....	29
Хүснэгт 2.4. Ажиллагчид, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр, мянган хүн.....	31
Хүснэгт 2.5. Байнгын ажиллагчид, салбар, ажил мэргэжлийн үндсэн бүлгээр, хувь	32
Хүснэгт 2.6. Түр ажиллагчид, салбар, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр, хувь	33
Хүснэгт 2.7. Шинэ ажиллагчдын эзлэх хувь, ажил мэргэжлийн үндсэн бүлгээр	35
Хүснэгт 2.8. Шинэ ажиллагчдын эзлэх хувь, ажил мэргэжлээр	36
Хүснэгт 2.9. Нээлттэй зарлагдсан ажлын байрны түвшин, салбараар	37
Хүснэгт 2.10. Шинэ болон халагдсан ажиллагчид, салбараар	38
Хүснэгт 2.11 Шинэ болон халагдсан ажиллагчид, ажил мэргэжлээр	39
Хүснэгт 2.12. Нээлттэй зарлагдсан ажлын байрны эзлэх хувь, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр.....	40
Хүснэгт 2.13. Нээлттэй зарлагдсан ажлын байрны эзлэх хувь, ажил мэргэжлийн ангиллаар.....	40
Хүснэгт 2.14. 2020 оны ажиллах хүчний эрэлт, салбар, хугацаагаар.....	47
Хүснэгт 2.15. Ажиллах хүчний эрэлт, ажлын байрны хэлбэр, салбараар	50
Хүснэгт 2.16. Ажиллах хүчний эрэлт, салбараар, ажлын байрны төрлөөр.....	51
Хавсралт хүснэгт 0.1. Ажиллах хүчний эрэлт, салбар, мянган хүнээр, 2012-2020 он	77
Хавсралт хүснэгт 0.2. Эрэлттэй ажил мэргэжил, 2013-2020 он	78
Хавсралт хүснэгт 0.3. Хомсдолтой ажил мэргэжил, 2014-2020 он	79

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. 2020 оны ажиллах оны ажиллах хүчний эрэлт, салбарын ангиллаар, хувиар	xi
Зураг 2. 2020 оны ажиллах хүчний эрэлт, салбарын ангиллаар, хувиар	xi
Зураг 1.1. Монгол улсын 15, түүнээс дээш насны хүн ам, мянган хүнээр, 2009-2018 он	14
Зураг 1.2. Ажиллах хүч, мянган хүн, 2009-2018 он	14
Зураг 1.3. Хөдөлмөр эрхлэлтийн зарим статистик үзүүлэлт, 2009-2018 он	15
Зураг 1.4. Бүртгэлтэй ажилгүй иргэн, насны бүлэг, хувиар.....	18
Зураг 1.5. Ажлын байрны захиалга, бүсээр, мянган хүнээр, 2014-2019 он	19
Зураг 1.6. Ажлын байрны захиалга, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр, мянган хүн....	20
Зураг 1.7. Ажилд зуучлагдсан иргэд, ажил мэргэжлийн үндсэн ангиллаар, мянган хүн	22
Зураг 1.8. Гадаад ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар /хувь/	23
Зураг 2.1. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын тоо, аймгаар	27
Зураг 2.2. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын хувь, өмчийн хэлбэр, байршлаар	28
Зураг 2.3. Ажиллагчдын эзлэх хувь, ажлын байрны хэлбэр, хүйсээр	30
Зураг 2.4. Байнгын болон түр ажиллагчдын хувь, боловсролын түвшинээр	31
Зураг 2.5. 2019 онд ААНБ-ууд шинээр ажилтан авах эсэх, бүсээр, хувиар	42
Зураг 2.6. 2020 оны эхний 6 сарын ажиллах хүчний эрэлт, ЭЗҮА-ны салбарын эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, хувиар.....	43
Зураг 2.7. 2020 оны сүүлийн 6 сарын ажиллах хүчний эрэлт, ЭЗҮА-ны салбарын ангилал, хувиар	44
Зураг 2.8. 2020 оны ажиллах хүчний эрэлт, салбарын ангилал, хувиар	45
Зураг 2.9. Ажиллагчдын тоо болон ажиллах хүчний эрэлт, салбарын ангиллаар, мянган хүн....	46
Зураг 2.10. 2020 оны ажиллах хүчний эрэлтийн хувь, бүсээр	48
Зураг 2.11. Ажиллах хүчний эрэлтийн эзлэх хувь, ААНБ-ын өмчийн хэлбэр, ажлын байрны төрлөөр.....	49
Зураг 2.12. Ажиллах хүчний эрэлтийн эзлэх хувь, ажлын байрны төрөл, өмчийн хэлбэрээр.....	52
Зураг 2.13. Сул ажлын байр бий болсон шалтгаан, хувиар.....	53
Зураг 2.14. Ажил олгогчдын чухалчилдаг ур чадварын шаардлага	56
Зураг 2.15. Ажиллагчдад чиглэсэн сургалт, арга хэмжээ, хувиар	57
Зураг 2.16. Зохих мэргэжилтэй ажилтан олдоогүйгээс ажилтан авч чадаагүй байдал, бүсээр, хувиар	58
Зураг 2.17. Ажиллах хүчний хомсдол, байгууллагын өмчийн хэлбэрээр, мянган хүнээр.....	60
Зураг 2.18. Шинэ ажилтан авахад ашигладаг мэдээллийн эх сурвалж, хувиар	62
Зураг 2.19. Шинээр ажилтан авахад болон ажиллуулахад тулгардаг нийтлэг бэрхшээл, хувиар	63
Зураг 2.20. Ажиллах хүчний эрэлт, мянган хүнээр, 2011-2020 он	64
Зураг 2.21. Ажиллах хүчний эрэлт, тэргүүлэх салбараар, мянган хүнээр	64
Зураг 2.22. Ажиллах хүчний эрэлт, бүс нутгаар, мянган хүнээр	65
Зураг 2.23. Ажиллах хүчний эрэлт, хугацаагаар, хувиар	66
Зураг 2.24. Ажиллах хүчний эрэлт, ажлын байрны хэлбэрээр, хувиар	66
Зураг 2.25. Ажиллах хүчний эрэлт, ажлын байрны төрлөөр, хувиар.....	67
Зураг 2.26. Ажиллах хүчний хомсдол, мянган хүнээр, 2013-2020 он.....	68

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХНХСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БРС	Бизнес регистрийн сан
ХАА	Хөдөө аж ахуй
ISIC	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал
ҮАМАТ	Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт
ISCO	Мэргэжлийн ангиллын олон улсын стандарт
ХЗЗ	Хөдөлмөрийн зах зээл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
САПИ	Computer-assisted personal interviewing

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Аж ахуйн нэгж

Улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд болон үндсэн үйл ажиллагаа нь ашгийн бус боловч бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлж орлого олсон дотоод, гадаадын хуулийн этгээдийг;

Ажлын байр

Иргэн, ажилтны гүйцэтгэх ажил үүрэгтэйгээ холбоотойгоор хүрэлцэн очих ёстой ажил олгогчийн шууд ба шууд бус хяналтын дор ажил гүйцэтгэх бүх байрыг;

Ажиллагч

Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ.

Ажил олгогч

Эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бие даан гаргаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон ашиг буюу ашиг олох боломжоос шууд хамаарах бизнестээ урт хугацаагаар нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн болон бусад гэрээ, тохиролцооны үндсэн дээр авч ажиллуулж буй эзэн, байгууллагын удирдлагыг;

Ажиллах хүч

Тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүнийг;

Ажиллах хүчний эрэлт

Ажил олгогчид хэрэгцээтэй хөдөлмөрийн үйлчилгээний хэмжээг;

Ажил хайгч

Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг;

Байнгын ажлын байр

Ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил үүргийг;

Байнгын ажилтан

Байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг;

Түр ажлын байр

Хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран зургаан сар хүртэлх хугацаагаар байгуулж, тодорхой нэг ажил үүргийг гүйцэтгэснээр

дуусгавар болдог, байнгын давтамжгүй, тохиолдлын шинж чанартай ажил үүрэг, албан тушаалыг;

Түр ажилтан

Хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран зургаан сар хүртэлх хугацаагаар байгуулж, цалин хөлс, орлого олдог, эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарах, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг өөрөө бие даан хариуцаж төлдөг иргэнийг;

Улирлын ажлын байр

Улирлын чанартай байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг ажил, үүрэг, албан тушаалыг;

Улирлын ажилтан

Улирлын чанартай байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг;

Шинэ ажлын байр

Эдийн засгийн үйл ажиллагааны хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох болон өргөтгөх замаар албан ба албан бус салбарт шинээр бий болсон ажил, үүрэг, албан тушаалыг;

Бүртгэлтэй ажилгүй хүн

Өнгөрсөн долоо хоногт буюу түүнээс өмнө ямар нэг шалтгаанаар ажилгүй болсон эсвэл халагдсан, халагдсан тушаалаа бичгээр авч ажил зуучлагчийн газар бүртгүүлсэн ажил идэвхтэй хайж байгаа ажилд ороход бэлэн хүнийг;

Төрийн өмчит хуулийн этгээдийн ойлголт

Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг;

Гадаад улсын хөрөнгө оруулалттай

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, өөрийн хөрөнгө нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх төгрөгөөс дээш, түүний 25-аас доошгүй хувь нь гадаадын хөрөнгө оруулагчийн хувь хөрөнгөөс бүрдсэн аж ахуйн нэгжийг;

Мэргэжилтэй ажилтан

Тодорхой ажил эрхлэх, мэдлэг ба зохих ур чадварыг зориулалтын сургалтаар олж авсан, эсвэл эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан мэргэжилтэй хүнийг;

Өөрийн хүсэлтээр халагдсан

Хууль болон хөдөлмөрийн гэрээнд өөрөөр заагаагүй бол ажилтан хөдөлмөрийн гэрээ цуцлах тухай өргөдлөө ажил олгогчид өгсөн өдрөөс хойш 30 хоног өнгөрмөгц ажлын байраа орхих эрхтэй, энэ тохиолдолд хөдөлмөрийн гэрээ цуцлагдсанд тооцно.

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгааны зорилго нь хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны /2020 он/ ажиллах хүчний эрэлтийг ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тодорхойлж, боловсрол сургалт, хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид болон судлаачдыг мэдээллээр хангахад оршино.

Энэ удаагийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаагаар Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн нийт 3642 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, 2020 оны ажиллах хүчний эрэлтийг тодорхойллоо. Судалгааны түүврийн 71.0 хувь буюу 2585 аж ахуйн нэгжийг Улаанбаатар хот, 29.0 хувь буюу 1057 ААНБ-ыг 21 аймгаас оролцууллаа.

2020 онд хөдөлмөрийн зах зээлд 72.7 мянган ажлын байр бий болох хүлээлттэй байгаа нь өмнөх оноос 4.8 хувиар өсөх үзүүлэлт бөгөөд уг эрэлт нь нийт ажиллагчдын тоог 6.3 хувиар өсгөх боломж олгох юм.

Судалгаагаар ажиллах хүчний нийт эрэлтийн 81.6 хувь буюу 59.3 мянга нь 2020 оны эхний хагаст, үлдсэн 18.4 хувь буюу 13.4 мянга нь сүүлийн хагас жилд бий болох төлөв ажиглагдлаа. Ажиллах хүчний нийт эрэлтийн 81.3 хувь нь байнгын ажлын байр байх хүлээлттэй байна. Мөн ажлын байрны төрлөөр 59.8 хувь нь шинэ, 40.2 хувь нь сул ажлын байранд үүсэх эрэлт эзэлж байна.

Ажиллах хүчний эрэлтийг салбараар тодруулбал бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудад хамгийн их эрэлт бий болох хандлагатай байгаа нь 2017 болон 2018 оны судалгааны үр дүнг давтсан үзүүлэлт болж байна. Иймээс дээрх салбарууд 2020 оны хөдөлмөрийн зах зээлд голлох эерэг нөлөөг үзүүлэхээр харагдаж байна. Харин усан хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамжийн үйл ажиллагааны салбар, урлаг үзвэр, тоглоом наадам, мэдээлэл холбоо, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, тээвэр, агуулахын үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбаруудад ажиллах хүчний эрэлт 9.3 мянга буюу нийт эрэлтийн 12.8 хувийг эзэлж байгаа нь хамгийн бага нөлөөтэй байхаар байна.

Хэдийгээр ажиллах хүчний эрэлтийн 20.0 хувийг барилгын салбарын эрэлт дангаараа бүрдүүлж байгаа ч өмнөх оноос 17.9 пунктээр, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 7.4 мянган ажиллах хүчний эрэлт бий болох төсөөлөлтэй байгаа нь өмнөх онтой харьцуулахад 27.7 пунктээр буурах хандлагатай байна. Харин бөөний болон жижиглэн худалдааны салбарт 16.7 мянган ажиллах хүчний эрэлт бий болох нь өмнөх оноос 26.2 пунктээр өсөх дүр зураг гарчээ.

Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбар, мэдээлэл, холбоо, тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбар, урлаг, үзвэр, тоглоом наадам, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын ажиллах хүчний эрэлт өмнөх оноос буурах төлөвтэй бол хөдөө аж ахуй, уул уурхайн олборлолт, цахилгаан, хий, уур, агааржуулалт, боловсрол, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын ажиллах хүчний эрэлт тус тус өсөх төлөвтэй байна.

Зураг 1. 2020 оны ажиллах оны ажиллах хүчний эрэлт, салбарын ангиллаар, хувиар



Эдийн засгийн үйл ажиллагааны бүх салбарын ажиллах хүчний эрэлтийн 68.0-аас дээш хувь нь оны эхний хагаст багтаж байгаа бөгөөд 10 ажлын байр тутмын 7 нь оны эхний хагас жилд бий болохоор байна.

Зураг 2. 2020 оны ажиллах хүчний эрэлт, салбарын ангиллаар, хувиар



■ Эхний хагас жил ■ Сүүлийн хагас жил

Ажил мэргэжлийн хувьд тухайн жилд ажиллах хүчний эрэлт өндөр байх салбарт харьяалагдах ажил мэргэжлийн эрэлт илүү өндөр байх төлөвтэй байна. Тухайлбал, ажиллах хүчний нийт эрэлтийн 11.0 хувийг барилгын туслах ажилтан, 1.2 хувийг сантехникч, хоолой засварчин, цахилгаанчин, гагнуурчин, сантехникч, хоолой угсрагч тус бүр 1.1 хувь зэрэг барилгын салбарын ажил мэргэжлийн эрэлт эзэлж байна.

Хүснэгт 0.1.Эрэлттэй ажил мэргэжил, дүнд эзлэх хувиар

Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь	Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь
1	931211	Туслах ажилтан, барилгын туслах	11.0	11	215111	Инженер, цахилгааны	1.4
2	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	4.8	12	833215	Жолооч, хогны машины	1.3
3	524212	Борлуулагч	3.9	13	751111	Мах махан бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан	1.3
4	911214	Цэвэрлэгч, албан байгууллагын	3.1	14	523011	Дэлгүүрийн кассчин	1.3
5	343412	Тогооч, ерөнхий	2.2	15	712612	Сантехникч, хоолой засварчин	1.2
6	241113	Ерөнхий нягтлан бодогч	2.1	16	221111	Их эмч, ерөнхий мэргэжлийн	1.1
7	833213	Жолооч, ачааны тэрэгний	1.9	17	832213	Жолооч, бага оврын, бүхээгт тэрэгний	1.1
8	222111	Сувилагч, ерөнхий мэргэжлийн	1.6	18	741111	Цахилгаанчин	1.1
9	541411	Харуул, гэрээт албаны	1.6	19	721214	Гагнуурчин	1.1
10	513111	Зөөгч	1.4	20	712611	Сантехникч, хоолой угсрагч	1.1

Хөдөлмөрийн зах зээлд 2019 онд зохих мэргэжилтэй ажилтан олдоогүйгээс шалтгаалан 17.7 мянган ажиллах хүчний хомсдол бий болсон бөгөөд бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбар хамгийн ихээр энэхүү хомсдолд өртсөн байна.

Ажил олгогчид сүүлийн 12 сард давхардсан тоогоор 89.1 мянган ажиллагчдыг ажлын байраар хангасан бол мөн хугацаанд 59.8 мянган иргэд ажлаас гарсан байна.

Ажил олгогчид шинээр ажилтан авч ажиллуулахад хамгийн их тохиолддог бэрхшээлд дараах зүйлсийг дурджээ. Тухайлбал, ажил олгогчдын нэрлэсэн бэрхшээлийн 18.8 хувийг ажиллагч тогтвортой ажиллах хүсэлгүй байх, 15.0 хувийг тухайн ажил хайгчийн ажлын туршлагагүй байдал, 14.5 хувийг ажлын ачаалал даах чадваргүй байдал, 13.9 хувийг ажлын байрны нөхцөл, цалин хөлс голдог гэсэн бэрхшээлүүд эзэлж байгаа нь нийт бэрхшээлийн 62.2 хувийг бүрдүүлж байна. Үүнээс харахад ажил хайгч иргэн тогтвортой ажиллах хүсэлгүй байх, ажлын хангалттай туршлагагүй байдал нь ажил олгогчдод шинээр ажилтан авахад тулгарч буй гол бэрхшээл болсон хэвээр л байна. Эдгээр хүндрэл бэрхшээл жил бүрийн судалгаагаар удаа дараа нэрлэгдсээр байгааг анхаарах хэрэгтэй.

БҮЛЭГ 1

**БҮЛЭГ 1. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ
ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**


1.1. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

Хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчийг бүрдүүлэгч нь тухай улсын хөдөлмөрийн насны иргэд байдаг бөгөөд бусдын хэрэгцээнд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхийг хөдөлмөр эрхлэлт гэж үздэг. Энэ бүлэгт Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлыг сүүлийн 10 жилээр авч үзлээ.

Ажиллах хүч

Монгол Улсын хувьд хүн амын тоо тогтмол өсөлттэй байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн насны хүн амын өсөлт буурах хандлагатай байна. Хөдөлмөрийн насны хүн ам 2018 онд¹ 2.2 саяд байсан ба тэдний 61.0 хувь нь эдийн засгийн идэвхтэй хүн ам байна.


Зураг 1.1. Монгол улсын 15, түүнээс дээш насны хүн ам, мянган хүнээр, 2009-2018 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2018 оны жилийн эцэст Монгол улсны ажиллах хүч 1358.6 мянган хүн байснаас 105.6 мянган хүн ажилгүй байгаа нь өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар буурч, ажилгүйдлийн түвшин 7.8 хувь болж буурсан үр дүн юм.

Зураг 1.2. Ажиллах хүч, мянган хүн, 2009-2018 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

¹ Судалгааны тайлан эцэслэх үед 2019 оны хүн амын тоо гараагүй байсан.

Ажиллах хүчний оролцооны түвшин нь хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувь нь ажиллах хүч байна гэдгийг харуулдаг бөгөөд сүүлийн 10 жилд 2012 онд хамгийн өндөр буюу 63.5 хувь байсан бөгөөд 2018 оны байдлаар 61.1 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан үзүүлэлт юм.

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин нь хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувь нь ажиллагч байгаа эсэхийг тодруулдаг бөгөөд сүүлийн 10 жилд 2012 онд хамгийн өндөр буюу 58.3 хувь байсан бөгөөд 2018 онд 56.3 хувь байгаа нь өмнөх оноос 0.5 пунктээр өссөн байна.

2009 оноос хойш ажилгүйдлийн түвшин буурсан бөгөөд 2016 онд огцом нэмэгдэж 10.0 хувь болсон бөгөөд сүүлийн 2 жилийн хугацаанд буурч байгаа бөгөөд 2018 оны байдлаар 7.8 хувь байна.

Зураг 1.3. Хөдөлмөр эрхлэлтийн зарим статистик үзүүлэлт, 2009-2018 он



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөлмөрийн зах зээлийн зарим үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулан хүснэгт 2.1-д бүсээр харуулав. Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо 2018 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 1.2 мянган хүнээр өссөн байна. Баруун бүс, Хангайн бүс, Төвийн бүсийн эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо буурсан бол Зүүн бүс болон Улаанбаатарт өссөн.

Хүснэгт 1.1. Ажиллах хүчний зарим статистик үзүүлэлт, бүсээр, мянган хүн

Бүс	Эдийн засгийн идэвхтэй хүн ам		Ажиллагчдын тоо		Ажилгүй иргэд		Ажилгүйдлийн түвшин	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Улсын дүн	1357.4	1358.6	1238.3	1253.0	119.1	105.6	8.8	7.8
Баруун	194.0	193.8	173.2	176.5	20.9	17.2	10.7	8.9
Хангайн	282.7	280.7	254.9	260.7	27.8	20.0	9.8	7.1
Төвийн	234.4	234.2	215.1	216.4	19.4	17.8	8.3	7.6
Зүүн	92.7	94.7	83.1	86.4	9.7	8.3	10.4	8.7
Улаанбаатар	553.6	555.3	512.2	513.1	41.4	42.3	7.5	7.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нийт ажиллагчдын 40.9 хувь нь Улаанбаатарт ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар буурсан бол Хангайн бүсэд 5.8 мянга (2.3 хувь)-аар өссөн нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Улсын хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар ажилгүй иргэдийн тоо өмнөх оноос буурсан бөгөөд Улаанбаатараас бусад бүсүүдэд буурсан байна. Үүнтэй холбоотойгоор ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд буурсан үзүүлэлттэй байна.

Ажил олгогчид

ҮСХ-ны мэдээгээр 2018 оны жилийн эцэст нийт 85.7 мянган ААНБ идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь 2017 оны мөн үеэс 9.0 хувиар өссөн үзүүлэлт юм. Хөдөө аж ахуй, Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж, Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгааллын салбараас бусад салбарт ажил олгогчийн тоо нэмэгдсэн бол бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт нийт өсөлтийн 47.9 хувь нь бий болжээ.

Хүснэгт 1.2. Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2017		2018	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хөдөө аж ахуйн, ан агнуур, ойн аж ахуй	3.8	4.9	3.8	4.5
Загас барилт	0.0	0.0	0.0	0.0
Уул уурхай, олборлох үйлдвэр	0.8	1.0	0.9	1.1
Боловсруулах үйлдвэр	5.8	7.4	6.2	7.3
Цахилгаан, хий үйлдвэрлэл, ус хангамж	0.2	0.3	0.3	0.3
Барилга	6.3	8.1	6.7	7.8
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны	30.5	38.8	33.9	39.6
Зочид буудал, зоогийн газар	2.3	2.9	2.4	2.8
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	2.9	3.7	3.3	3.8
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	1.2	1.5	1.3	1.5
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	7.6	9.6	8.3	9.7
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгаалал	1.5	1.9	1.5	1.7
Боловсролын салбарын үйл ажиллагаа	3.6	4.5	3.8	4.5
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	3.4	4.3	3.8	4.5
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	8.8	11.2	9.4	11.0
Нийт	78.6	100.0	85.7	100.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ыг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар нь авч үзвэл 39.6 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 11.0 хувь нь нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйл ажиллагааны салбарт, 9.7 хувь нь үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагааны салбарт, 7.8 хувь нь барилгын салбарт, 7.3 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 4.5 хувь нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 1.3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2017		2018	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	356.4	28.8	334.1	26.7
Уул уурхай, олборлолт	52.0	4.2	57.7	4.6
Боловсруулах үйлдвэрлэл	93.1	7.5	100.8	8.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	17.5	1.4	16.3	1.3
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	4.9	0.4	6.9	0.5
Барилга	70.6	5.7	76.6	6.1
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	204.5	16.5	211.2	16.9
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	72.7	5.9	73.6	5.9

Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	36.4	2.9	37.5	3.0
Мэдээлэл, холбоо	14.5	1.2	14.1	1.1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	24.1	1.9	25.7	2.1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.4	0.0	0.8	0.1
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	12.7	1.0	14.6	1.2
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	20.8	1.7	18.2	1.5
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	82.2	6.6	76.2	6.1
Боловсрол	98.9	8.0	98.7	7.9
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	40.0	3.2	49.5	3.9
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	10.1	0.8	13.8	1.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	22.7	1.8	23.4	1.9
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	2.3	0.2	1.2	0.1
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1.5	0.1	2.3	0.2
Нийт	1238.3	100.0	1253.0	100.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хэдийгээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоо болон ажиллагчдын тоо өссөн хэдий ч зарим салбарт ажиллагчдын тоо буурсан байна. Тухайлбал хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж, мэдээлэл, холбоо, захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, боловсрол, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагааны салбарын ажиллагчдын тоо тус тус буурчээ. Харин хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа, боловсруулах үйлдвэрлэл, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарын ажиллагчдын тоо тус тус өссөн нь нийт ажиллагчдын тоо өсөхөд голлон нөлөөлжээ.

1.2. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН

Бүртгэлтэй ажилгүй хүн гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлээгүй, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлэхэд бэлэн болон Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн ажилгүй хүнийг хэлэх бөгөөд 2019 онд ХХҮЕГ-т 20.7 мянган ажилгүй иргэн бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар буурсан байна. Байршлаар авч үзвэл 32.3 хувь нь Улаанбаатар хотод, 22.1 хувь нь Хангайн бүсэд, 19.4 хувь нь баруун бүсэд, 15.5 хувь нь төвийн бүсэд, 10.7 хувь нь зүүн бүсэд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшний хувьд авч үзвэл 0.9 хувь нь магистр, доктор, 25.7 хувь нь дипломын болон бакалаврын дээд, 10.9 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 52.9 хувь нь бүрэн дунд, үлдсэн 9.6 хувь нь бүрэн дундаас доош боловсролтой иргэд байна.


Хүснэгт 1.4. Бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, бүсээр, 2019 он

Байршил	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дипломын болон бакалаврын дээд	Магистр, доктор	Нийт
Баруун бүс	79	125	300	1994	316	254	962	7	4037
Хангайн бүс	58	153	416	2697	290	126	836	8	4584
Төвийн бүс	29	49	174	1649	238	183	867	24	3213
Зүүн бүс	48	73	184	1146	248	97	414	5	2215
Улаанбаатар	72	44	196	3495	235	286	2250	134	6712
Нийт	286	444	1270	10981	1327	946	5329	178	20761

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны бүлгээр авч үзэхэд 20.9 хувь нь 15-24 насны, 36.5 хувь нь буюу хамгийн их нь 25-34 насны, 24.1 хувь нь 35-44 насны, 4.0 хувь нь 55-аас дээш насныхан байна.

Зураг 1.4. Бүртгэлтэй ажилгүй иргэн, насны бүлэг, хувиар




Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

1.3. АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, АЖИЛД ЗУУЧЛАЛ

Манай байгууллагын өмнөх жилийн судалгааны үр дүнгээс 2019 онд хөдөлмөрийн зах зээлд 69.4 мянган ажиллах хүчний эрэлт үүснэ хэмээн таамагласан. ХХҮЕГ-ын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ болон хувийн хөдөлмөрийн биржүүдийн хүрээнд 2019 оны ажлын байрны захиалгын мэдээгээр 71.1 мянган ажлын байр нээлттэй зарлагдсан нь өмнөх оны мөн үеэс 10.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 1.5. Ажлын байрны захиалга, бүсээр, мянган хүнээр, 2014-2019 он²



Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажлын байрны захиалга Төвийн бүсэд 46.5 хувь, Баруун бүсэд 5.1 хувиар тус тус өссөн бол Хангайн бүсэд 11.6 хувиар буурч, зүүн бүсэд хэвээр байна.

2019 онд нийт ажлын байрны захиалгын 34.8 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын ажлын байр, 13.6 хувийг уул уурхай, олборлолтын ажлын байрны захиалга эзэлж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын хувьд ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан, хий, уур, агааржуулалт, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа Урлаг, үзвэр, тоглоом наадам зэрэг салбарын хувьд ажлын байрны захиалга буурсан хэдий ч уул уурхай, олборлолтын ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 83.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1.5. Ажлын байрны захиалга, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, 2014-2019 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2014	2015	2017	2018	2019
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	8.4	5.7	4.3	4.7	4.4
Уул уурхай, олборлолт	7.2	5.5	5.3	5.3	9.7
Боловсруулах үйлдвэрлэл	16.2	7.8	5.8	6.1	6.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1.0	0.9	0.5	0.6	0.6
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.9	0.7	1.0	0.6	0.8
Барилга	27.8	13.4	4.4	6.9	6.9
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	7.6	4.2	2.5	2.4	3.4
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	3.1	1.6	0.7	0.8	0.8
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	3.5	2.1	1.2	2.0	1.4
Мэдээлэл, холбоо	0.6	0.3	0.2	0.5	0.6
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.0	0.7	0.6	1.0	1.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.2	0.1	0.1	0.0	0.0

² ХХҮЕГ-аас гаргадаг ажлын байрны захиалга, ажилд зуучлалын 2016 оны мэдээ байхгүй.

Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.2	0.1	0.1	0.1	0.1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.7	0.5	1.6	1.8	1.5
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2.3	2.4	2.8	1.3	1.9
Боловсрол	4.0	3.5	3.9	3.7	4.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1.8	1.6	1.9	3.6	2.0
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.5	0.4	0.4	0.5	0.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	26.4	25.2	24.1	21.9	24.8
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	1.2	0.8	1.2	0.5	0.6
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.0	0.1	0.1	0.1	0.3
Нийт	114.4	77.7	62.6	64.5	71.1

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажил мэргэжлийн ангиллын хувьд “Энгийн ажил мэргэжил”, “Мэргэжилтэн”, “Худалдаа үйлчилгээний ажилтан” бүлгийн ажил мэргэжлийн захиалга нийт захиалгад голлох жинтэй буюу нийт захиалгын 50 гаруй хувийг эзэлж байна. Үүнээс “Энгийн ажил мэргэжил” бүлгийн ажлын байрны захиалга хамгийн их буюу 27 хувийн өсөлттэй байсан бол “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан” бүлгийн ажил мэргэжлийн захиалга 13.5 хувь буюу хамгийн ихээр буурчээ.

Тодруулбал, 2019 оны ажлын байрны захиалгын 13.8 хувь буюу 9.8 мянга, 2018 оны захиалгын 17.6 хувь буюу 11.3 мянган ажлын байрны захиалга нь “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан” чиглэлийн ажлын байр байжээ.

Зураг 1.6. Ажлын байрны захиалга, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр, мянган хүн



Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Энэхүү захиалгын дагуу 2019 оны жилийн эцсийн байдлаар 44.1 мянган ажилгүй иргэн ажилд зуучлагдан орсон байна. 2018 оны ажилд зуучлагдсан нийт иргэдийн 42.5 хувь буюу 18.7 мянга нь Улаанбаатар хотод, 18.6 хувь нь (8.2 мянга) Хангайн бүсэд, 16.1 хувь нь (7.1 мянга) Төвийн бүсэд, 13 хувь нь (5.7 мянга) Баруун бүсэд, 9.8 хувь нь (4.3 мянга) Зүүн бүсэд тус тус харьяалагдаж байна.

Хүснэгт 1.6. Ажилд зуучлагдсан иргэд, бүсээр, мянган хүн, 2014-2019 он

Бүс	2014	2015	2017	2018	2019
Баруун бүс	6.9	6.0	6.5	5.6	5.7
Хангайн бүс	13.2	9.1	10.1	8.3	8.2
Төвийн бүс	9.0	7.5	6.6	6.6	7.1
Зүүн бүс	4.5	4.1	4.4	4.2	4.3
Улаанбаатар	20.8	23.0	18.0	18.4	18.7
Улсын дүн	54.4	49.7	45.7	43.1	44.1

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Ажлын байранд зуучлагдсан иргэдийг өмнөх онтой харьцуулан, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тодруулбал, Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт зуучлагдсан иргэдийн тоо 13.4 хувиар буурсан бол Уул уурхай, олборлолт салбарт ажлын байрны захиалга өссөнтэй холбоотойгоор ажилд зуучлагдсан иргэдийн тоо 13.3 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

Хүснэгт 1.7. Ажилд зуучлагдсан иргэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн, 2014-2019 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажилд зуучлагдсан иргэн				
	2014	2015	2017	2018	2019
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур,	6.5	4.6	3.5	3.4	3.1
Уул уурхай, олборлолт	3.6	3.1	4.0	3.6	4.9
Боловсруулах үйлдвэрлэл	7.7	5.7	3.6	4.9	4.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.5	0.5	0.4	0.4	0.4
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.7	0.6	0.7	0.4	0.7
Барилга	9.7	6.8	2.8	3.6	4.1
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	3.4	3.0	2.0	2.8	2.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.2	1.1	0.6	0.5	0.5
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1.6	1.5	1.0	0.7	1.1
Мэдээлэл, холбоо	0.2	0.2	0.1	0.2	0.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0.7	0.6	0.5	0.8	0.4
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.1	0.0	0.1	0.0	0.0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.1	0.1	0.0	0.1	0.1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.5	0.5	1.4	1.5	1.4
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1.7	2.0	2.4	1.1	1.3
Боловсрол	3.0	2.9	3.4	2.9	3.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1.1	1.2	1.6	1.2	1.5
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.2	0.3	0.3	0.3	0.5
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	10.8	14.2	16.5	14.2	12.3
Хүн хөлсөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.9	0.7	0.6	0.3	0.5
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.0	0.1	0.1	0.0	0.3
Нийт	54.3	49.7	45.7	43.1	44.1

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2019 оны ажилд зуучлагдсан иргэдийн 27.9 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт, 11.1 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт, 10.6 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажилд зуучлагдан оржээ.


Ажилд зуучлал

2019 оны нийт 71.1 мянган ажлын байрны захиалгын 62 хувь буюу 44.1 мянган ажлын байранд иргэд зуучлагджээ.

Ажилд зуучлагдсан иргэдийг ажил мэргэжлийн хувьд авч үзвэл 21.4 хувь нь “Мэргэжилтэн”, 18.1 хувь нь “Энгийн ажил мэргэжил”, 14.8 хувь нь “Контор, үйлчилгээний ажилтан” бүлгийн ажил мэргэжлийн ажлын байранд зуучлагдсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Зэвсэгт хүчний ажил, мэргэжил” бүлгийн ажилд зуучлагдсан иргэдийн тоо 47 хувь, “Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч” бүлэг 29.3 хувь, Техникч болон туслах/дэд мэргэжилтэн чиглэлийн ажилд зуучлагдсан иргэдийн тоо 20.2 хувиар тус тус өссөн байна.

Харин менежер болон үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, контор, үйлчилгээний ажилтны ажлын байранд зуучлагдсан иргэдийн тоо тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 1.7. Ажилд зуучлагдсан иргэд, ажил мэргэжлийн үндсэн ангиллаар, мянган хүн



Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн хүрээнд Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэд хөдөлмөрийн зах зээл дэх ажиллагчдын тодорхой хувийг бүрдүүлж байдаг. Тухайлбал, 2017 онд 16.5 мянга, 2018 онд 10.7 мянга, 2019 онд 10.7 мянган гадаад ажиллах хүч манай оронд хөдөлмөр эрхэлсэн байна.

Манай улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж буй гадаад ажиллагчдын тоо өнгөрсөн жилийнхээс төдийлөн өөрчлөгдөөгүй хэдий ч эдийн засгийн үйл ажиллагааны салбар хооронд нэлээд өөрчлөлт орсон байна. Тухайлбал 2018 онд манай улсад хөдөлмөр эрхэлсэн нийт гадаад ажиллах хүчний 3.5 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт ажиллаж байсан бол

2019 онд 26.9 хувь болж өссөн. Харин боловсруулах үйлдвэрлэлийн салбарын гадаад ажиллах хүчний эзлэх хувь 2018 онд 20.3 хувь, 2019 онд 9.2 хувь болж 11.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гадаад ажиллагчдын тоо ихэнх салбарт буурсан хэдий ч уул уурхай, олборлолтын салбарт 23.4 пунктээр, боловсролын салбар 5.9 пунктээр, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарын гадаад ажиллагчдын тоо 2.6 пунктээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Манай улсад 2019 онд хөдөлмөр эрхэлсэн гадаадын иргэдийн 28.7 хувь нь барилга, 26.9 хувь нь уул уурхай, олборлолтын, 21.4 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 5.9 хувь нь боловсролын салбарт, үлдсэн хувь нь бусад салбарт тус тус ажиллаж байна.

Зураг 1.8. Гадаад ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар /хувь/



Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

2019 онд хөдөлмөр эрхэлж буй гадаад ажиллагчдыг ажил мэргэжлийн ангиллын хувь авч үзвэл мэргэжилтэн 24.5 хувь, Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан 23.5 хувийг эзэлж буй нь голлох хувийг эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад энгийн ажил мэргэжил, болон үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтнуудын эзлэх хувь нэлээд өсчээ.

Хүснэгт 1.8. 2019 онд хөдөлмөр эрхэлж буй гадаад ажиллагчдын хувь, ажил мэргэжлийн үндсэн бүлгээр

Ажил мэргэжлийн үндсэн бүлэг		Дүнд эзлэх хувь
1	Менежер	3.6
2	Мэргэжилтэн	24.5
3	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	14.3
4	Контор, үйлчилгээний ажилтан	0.7
5	Худалдаа, үйлчилгээний ажилтан	0.2
6	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	0.0

7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	23.5
8	Төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	17.7
9	Энгийн ажил, мэргэжил	15.4
10	Зэвсгэт хүчний ажил, мэргэжил	0.0

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Гадаад ажиллагчдыг ажил мэргэжил бүрээр харвал уул уурхай, барилга болон үйлдвэрийн инженер, техникийн ажилтан болон холбогдох бусад мэргэжилтний эзлэх хувь нэлээд дээгүүр эрэмбэлэгдэж байна. Өндөр хувьтай байна. Мөн багш, тогооч зэрэг ажиллагчдын тоо тодорхой хувийг эзэлж байна.

Хүснэгт 1.9. Гадаад ажиллагчид, ажил мэргэжлээр

ҮАМАТ-08 үндсэн бүлгийн код	Ажил мэргэжлийн нэр	Нийт дүн	Эзлэх хувь
2	Уул уурхайн инженер, металлургич, холбогдох бусад мэргэжилтэн	1176	11.1
2	Иргэний барилга байгууламжийн инженер	479	4.5
2	Багш	464	4.4
2	Багшлах мэргэжилтэн	422	4.0
2	Энэ ангилалд ороогүй инженер мэргэжилтэн	409	3.9
2	Мэргэжилтэн	406	3.8
2	Цахилгааны инженер	388	3.7
2	Механикч инженер	345	3.2
3	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	327	3.1
3	Механик инженерийн техникч	297	2.8
3	Уурхай металургийн техникч	268	2.5
3	Тогооч	247	2.3
7	Гагнуурчин	216	2.0
7	Барилга, түүнтэй холбогдох ажил, мэргэжлийн ажилтан /цахилгаанчнаас бусад/	201	1.9
7	Өрлөгчин, холбогдох бусад ажилтан	193	1.8
7	Барилгачин	171	1.6
7	Энэ ангилалд ороогүй барилгын араг бүтээц /яс мод/угсрагч түүнтэй адилтгах бусад ажилтан	165	1.6
7	Металл хийц бэлтгэгч, угсрагч	162	1.5
7	Шаварчин, засалчин	155	1.5
7	Бетончин, бетон гадаргуу өнгөлөгч түүнтэй холбогдох мэргэжлийн ажилтан	155	1.5
8	Хүнд даацын машин, том тэрэгний жолооч	147	1.4
8	Цооног өрөмдөгч, адилтгах бусад ажилтан	146	1.4
8	Газар шороо, зам засварын болон түүнтэй адилтгах машины операторч	116	1.1
8	Далд ба ил уурхайчин	112	1.1
8	Операторч, эрдэс чулуулаг боловсруулах төхөөргийн	111	1.0
9	Барилга угсралтын ажилтан	100	0.9
9	Барилга угсралтын туслах ажилтан	96	0.9
9	Энгийн ажил, мэргэжил	92	0.9

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлөөр ажиллаж буй гадаад ажиллагчдын 41.8 хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай компанид, 34.4 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай компанид, 10 хувь боловсрол, шинжлэх ухааны байгууллагад, 4.3 хувь нь гадаадын байгууллагын төлөөлөгчийн газарт, 4 хувь нь төрийн бус байгууллагад тус тус ажиллаж байна.

Хүснэгт 1.10. Гадаад ажиллагчдын эзлэх хувь, байгууллагын өмчийн хэлбэрээр

Өмчийн хэлбэр	Дүнд эзлэх хувь
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	41.8
Гадаадын хөрөнгө оруулалттай компани	34.4
Боловсрол, шинжлэх ухааны байгууллага	10.0
Гадаадын байгууллагын төлөөлөгчийн газар	4.3
Төрийн бус байгууллага	4.0
Улсын Үйлдвэрийн Газар	1.7
Хувьцаат Компани	1.3
Шашны Байгууллага	1.0
Төрийн байгууллага	0.7
Бусад	0.3
Олон улсын байгууллага	0.3

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

БҮЛЭГ 2


**БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ ҮНДСЭН
ҮР ДҮН**

2.1. СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэ удаагийн “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа”-ны түүврийн хэмжээг өргөтгөн өмнөх жилээс 38.5 хувиар нэмэгдүүлсэн бөгөөд Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн, 18 салбарын 3642 аж ахуйн нэгж, байгууллагыг хамрууллаа.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын 71.0 хувь нь буюу 2585 нь Улаанбаатар хотын ААНБ-ууд байгаа нь өмнөх жилийн судалгаанд хамрагдсан ААНБ-аас 53.8 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 2.1. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын тоо, аймгаар



Судалгаанд хамрагдсан ААНБ-ын 77.6 хувь нь байнгын үйл ажиллагаа явуулдаг бол 15.8 хувь нь улирлын чанартай, үлдсэн хувь нь үйл ажиллагаа нь тогтмол бус ААНБ-ууд байна.


Хүснэгт 2.1. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар, үйл ажиллагааны хэлбэрээр

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Нийт	Үйл ажиллагааны хэлбэр		
		Байнгын	Улирлын	Тогтмол биш
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	202	79	103	20
Уул уурхай, олборлолт	165	75	69	21
Боловсруулах үйлдвэрлэл	345	243	77	25
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	70	54	12	4
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	67	55	6	6
Барилга	294	141	120	33
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ	313	264	29	20
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	227	180	30	17
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	272	242	19	11

Мэдээлэл, холбоо	115	99	4	12
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	124	114	4	6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	239	215	12	12
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	135	107	18	10
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	267	193	53	21
Боловсрол	270	261	7	2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	214	211	2	1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	76	70	3	3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	247	225	7	15
Нийт	3642	2828	575	239

Ажиллагчдын тооны хувьд 45.1 хувь нь 30 хүртэлх ажиллагчидтай ААНБ бол 17.7 хувь нь 50-149 хүртэлх ажиллагчидтай, 16.7 хувь нь 150-аас дээш ажиллагчидтай байна. 150 болон түүнээс дээш ажилтантай таван аж ахуйн нэгж бүрийн дөрөв нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ хамрагдсан байна.

Зураг 2.2. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын хувь, өмчийн хэлбэр, байршлаар



Судалгаанд хамрагдсан ААНБ-ын 80.5 хувь нь хувийн өмчийн, 15.5 хувь нь төрийн, 4.0 хувь нь гадаад улсын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд байна. Улаанбаатар хотын ААНБ-ын 84.1 хувь нь хувийн, 10.7 хувь нь төрийн өмчийн байгууллага байгаа бол орон нутгийн түвшинд дээрх үзүүлэлт 71.5 ба 27.1 хувь байна.

Ажиллагчид

Судалгааны мэдээлэл цуглуулалтын үед эдийн засгийн 18 салбарын ААНБ-ын хүрээнд нийт 613.5 мянган ажиллагчид ажиллаж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, ажиллагчдын 18.9 хувь /116.2 мянга/ нь бөөний болон жижиглэн худалдааны, 17.3 хувь /106.0 мянга/ нь боловсролын, 8.4 хувь /51.5 мянга/ нь боловсруулах үйлдвэрлэлийн, 7.5 хувь /46.1 мянга/ нь хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны, 6.3 хувь /38.4 мянга/ нь уул уурхай, олборлолтын салбарт, тус тус харьяалагдаж байна.

Судалгааны мэдээлэл цуглуулалтын үе дэх хөдөлмөр эрхлэлт өнгөрсөн оны мөн үеэс 1.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэвч эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харвал зарим салбарт хөдөлмөр эрхлэлт буурсан байна. Тухайлбал хөдөө аж ахуй, уул уурхайн олборлолт,

боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан хий, агааржуулалт, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын хөдөлмөр эрхлэлт тус тус буурчээ.

Хүснэгт 2.2. Хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлт, мян. хүн

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Өнгөрсөн оны ажиллагчдын тоо	Энэ оны ажиллагчдын тоо	Ажиллагчдын тооны өөрчлөлт	
			Тоо	Хувь
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	10.2	9.4	-0.8	-7.7
Уул уурхай, олборлолт	39.2	38.4	-0.8	-2.1
Боловсруулах үйлдвэрлэл	52.0	51.5	-0.4	-0.9
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	17.3	16.9	-0.4	-2.3
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	6.9	6.9	0.0	0.2
Барилга	49.2	50.2	1.0	2.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ	111.2	116.2	5.0	4.5
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	23.6	25.0	1.4	6.1
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	20.9	20.4	-0.4	-2.1
Мэдээлэл, холбоо	13.2	13.9	0.7	5.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	16.3	16.9	0.5	3.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	9.6	9.7	0.1	1.3
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	23.4	24.2	0.7	3.2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	21.5	21.7	0.2	1.0
Боловсрол	103.2	106.0	2.8	2.7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	45.4	46.1	0.8	1.7
Урлаг, үзвэр, тоглоом наадам	9.8	9.9	0.1	1.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	30.3	30.1	-0.2	-0.7
Нийт	603.2	613.5	10.3	1.7

Байнгын хөдөлмөр эрхлэлт 0.9 хувиар өссөн бол түр хөдөлмөр эрхлэлт 12.4 хувиар өссөн нь анхаарал татсан асуудал болж байна. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлж сард 420.0 мянган төгрөг болгох шийдвэр нь түр ажил эрхлэлт өсөхөд нөлөөлсөн байж болох талтай.

Бүс нутгийн хувьд Хангай болон Төвийн бүсэд хөдөлмөр эрхлэлт буурсан чиг хандлагатай бол бусад бүсүүдэд өссөн дүр зурагтай байна. Тухайлбал Улаанбаатар хотод 2.5 хувь, баруун бүсэд 7.2 хувиар тус тус өсчээ. Байгууллагын өмчийн хэлбэрийн хувьд зөвхөн хувийн хамтарсан өмчийн хэлбэрийн ААНБ-дад хөдөлмөр эрхлэлт буурсан төлөвтэй байна.

Хүснэгт 2.3. Судалгаанд хамрагдсан ААНБ-ын ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар


Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажиллагчдын тоо		
	Нийт	Байнгын	Түр
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	9.4	7.5	1.9
Уул уурхай, олборлолт	38.4	36.2	2.2
Боловсруулах үйлдвэрлэл	51.5	46.5	5.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	16.9	16.2	0.8
Ус хангамж сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	6.9	6.4	0.4

Барилга	50.2	43.0	7.3
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	116.2	106.2	10.0
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	25.0	23.5	1.5
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	20.4	18.7	1.7
Мэдээлэл, холбоо	13.9	12.2	1.7
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	16.9	16.2	0.7
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	9.7	9.3	0.4
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	24.2	21.6	2.6
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	21.7	19.5	2.2
Боловсрол	106.0	102.7	3.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	46.1	44.5	1.6
Урлаг, үзвэр, тоглоом наадам	9.9	9.6	0.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	30.1	28.3	1.8
Нийт	613.5	568.0	45.5

Ажиллагчдын 92.6 хувь нь байнгын ажлын байранд, үлдсэн хувь нь түр ажлын байранд ажиллаж байна.


Нийт ажиллагчдын 48.6 хувь, байнгын ажиллагчдын 47.5 хувь нь эрэгтэй ажиллагчид байгаа бол түр ажиллагчдын 61.5 хувийг эрэгтэй ажиллагчид бүрдүүлж байна.

Зураг 2.3. Ажиллагчдын эзлэх хувь, ажлын байрны хэлбэр, хүйсээр



Байнгын ажиллагчдын 55.5 хувь нь бакалавр болон түүнээс дээш, 21.7 хувь нь бүрэн дунд боловсролтой ажиллагчид байна. Бакалаврын болон түүнээс дээш боловсролтой байнгын ажиллагчдын 60.9 хувь нь эмэгтэйчүүд бол бүрэн дунд боловсролтой ажиллагчдын 58.9 хувь нь эрэгтэй ажиллагчид байна. Бага боловсролтой болон боловсролгүй ажилтны тоо хамгийн бага буюу 2.3 мянга байгаа нь нийт байнгын ажилтны 0.4 хувийг эзэлж байна.

Зураг 2.4. Байнгын болон түр ажиллагчдын хувь, боловсролын түвшинээр



Түр ажиллагчдын 39.5 хувь нь буюу 18.0 мянга нь бүрэн дунд боловсролтой ажиллагчид байгаагийн 65.9 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Мөн түр ажиллагчдын 27.9 хувь буюу 12.7 мянга нь бакалавр зэрэгтэй, 22.6 хувь буюу 10.3 мянга нь техник мэргэжлийн болон мэргэжлийн анхан шатны боловсролтой ажиллагчид байгаа бөгөөд 66.6 хувь нь бакалавраас доош түвшний боловсролтой, эсвэл боловсролгүй ажиллагчид байна.

Ажиллагчдын ажил мэргэжлийн чиглэл

Судалгаанд хамрагдсан ААНБ-д ажиллаж буй нийт ажиллагчдын 92.6 хувь буюу 568.0 мянга нь байнгын ажлын байранд, үлдсэн 7.4 хувь буюу 45.5 мянга нь түр ажлын байранд ажиллаж байна. Байнгын ажиллагчдын 52.5 хувь, түр ажиллагчдын 38.4 хувийг эмэгтэй ажиллагчид эзэлж байна.

Байнгын ажиллагчдын 31.5 хувь буюу 179.1 мянга нь “Мэргэжилтэн”, 15.8 хувь буюу 89.6 мянга нь “Менежер”, 11.4 хувь буюу 64.6 мянга нь “Худалдаа, үйлчилгээний ажилтан”, 11.8 хувь буюу 67.0 мянга нь “Энгийн ажил мэргэжил”, ажил мэргэжлийн бүлэгт тус тус хамаарч байна. Харин түр ажиллагчдын 11.6 мянга (25.5 хувь) нь “Энгийн ажил мэргэжил”, 9.8 мянга (21.5 хувь) нь “Мэргэжилтэн”, 6.1 мянга нь (13.3 хувь) нь “Худалдаа, үйлчилгээний ажилтан”, 5.5 мянга (12.1 хувь) нь “Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч” бүлэгт хамаарах ажил мэргэжлийн ажиллагчид байна.

Хүснэгт 2.4. Ажиллагчид, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр, мянган хүн

Үндсэн бүлгийн дугаар	Ажил мэргэжлийн ангилал	Байнгын ажиллагчид		Түр ажиллагчид	
		Нийт	Үүнээс: эмэгтэй	Нийт	Үүнээс: эмэгтэй
1	Менежер	89.6	44.9	2.0	0.6
2	Мэргэжилтэн	179.1	121.6	9.8	5.0
3	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	45.8	26.0	2.6	1.2
4	Контор үйлчилгээний ажилтан	27.5	16.3	1.9	0.7
5	Худалдаа, үйлчилгээний ажилтан	64.6	38.7	6.1	3.8
6	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	1.1	0.5	0.9	0.2
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	39.1	11.2	5.1	1.3

8	Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	54.3	5.2	5.5	0.5
9	Энгийн ажил мэргэжил	67.0	33.4	11.6	4.2

Ажил мэргэжлийн хувьд “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт”-ын 4 оронтой нэгж бүлгийн дагуу авч үзсэн бөгөөд байнгын ажиллагчдын 5.6 хувь нь “Захирал, гүйцэтгэх захирал”, 4.6 хувь нь “Дунд боловсрол олгох багш”, 3.8 хувь нь “Нягтлан бодогч”, 2.0 хувь нь “Дээд боловсрол олгох багш”, 2.4 хувь нь “Нарийн мэргэжлийн” болон “Ерөнхий мэргэжлийн их эмч”, 1.9 хувь нь “Сувилахуйн мэргэжилтэн” мэргэжлийн ажиллагчид байгаа бол 3.3 хувийг “Хүнд даацын машин, том тэрэгний жолооч”, 2.0 хувийг “Зочид буудал, албан контор, бусад байгууллагын цэвэрлэгч, туслагч”, 1.9 хувийг “Энэ ангилалд ороогүй үйлдвэрийн бусад ажилтан”, 1.7 хувийг “Машин, такси болон бүхээгт тэрэгний жолооч”, 1.6 хувийг “Хамгаалалтын албаны ажилтан”, 1.4 хувийг “Тогооч” гэсэн ажил мэргэжлийн ажиллах хүчин тус тус эзэлж байна.

Түр ажиллагчдын хувьд мөн дээрх “Хүнд даацын машин, том тэрэгний жолооч, “Энэ ангилалд ороогүй үйлдвэрийн бусад ажилтан”, “Машин, такси болон бүхээгт тэрэгний жолооч”, “Хамгаалалтын албаны ажилтан”, “Автобус, троллейбус, трамвайны жолооч” гэх ажил мэргэжлийн бүлгийн ажиллагчид багагүй хувийг эзэлж байна. /Хавсралт 7/

Дээрх бүлгийн ажил мэргэжлийн ажиллагчид салбар бүрт түгээмэл тохиолдож байгаатай холбоотой, эдгээр ажил мэргэжлийн ажиллах хүчний хөдөлгөөн бусад ажил мэргэжлийн ажиллагчидтай харьцуулахад илүү өндөр байх нь тодорхой байна.

Байнгын ажиллагчдын ажил мэргэжлийн чиглэлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харвал салбарын онцлогоос шалтгаалан харилцан адилгүй бүтэцтэй байна. Тухайлбал, барилгын салбарын байнгын ажиллагчдын 24.2 хувийг “Мэргэжилтэн”, 20.3 хувийг “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан”, 14.7 хувийг “Менежер”, 14.0 хувийг “Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч”, 13.7 хувийг энгийн ажил мэргэжлийн ажиллагчид эзэлж байгаа нь барилгын салбарын байнгын ажиллагчдын 86.9 хувийг бүрдүүлж байна. Бөөний болон жижиглэн худалдааны салбарын хувьд байнгын ажиллагчдын 26.7 хувийг “Менежер”, 22.9 хувийг “Худалдаа, үйлчилгээний ажилтан”, 16.7 хувийг “Мэргэжилтэн” бүлгийн ажиллагчид эзэлж байна. Харин тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын байнгын ажиллагчдын 56.7 хувийг “Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч”, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын 60.4 хувь, боловсролын салбарын байнгын ажиллагчдын 62.9 хувийг “Мэргэжилтэн” бүлэгт хамаарах ажил мэргэжлийн ажиллагчид тус тус дангаараа бүрдүүлж байна.

Хүснэгт 2.5. Байнгын ажиллагчид, салбар, ажил мэргэжлийн үндсэн бүлгээр, хувь

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлэг								
	Менежер	Мэргэжилтэн	Техникч болон туслах/дэд	Контор үйлчилгээний ажилтан	Худалдаа, үйлчилгээний ажилтан	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох	Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	Энгийн ажил мэргэжил
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	21.9	16.8	7.4	6.9	6.3	7.4	6.8	12.3	14.4
Уул уурхай, олборлолт	13.1	13.7	9.5	5.3	4.0	0.0	5.3	33.5	15.7
Боловсруулах үйлдвэрлэл	14.7	16.6	7.1	7.7	5.7	0.2	18.2	11.2	18.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3.5	26.4	9.9	5.8	1.0	0.0	21.3	17.4	14.7

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	4.2	12.4	7.2	2.0	2.0	0.1	17.8	15.5	38.7
Барилга	14.7	24.2	8.2	2.1	2.7	0.0	20.3	14.0	13.7
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	26.7	16.7	7.5	4.4	22.9	0.1	5.9	6.9	9.0
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	15.3	7.0	4.3	4.1	2.9	0.0	4.9	56.7	4.8
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	16.1	7.0	14.4	4.6	31.8	0.2	1.9	2.6	21.3
Мэдээлэл, холбоо	19.9	46.0	14.1	9.7	2.0	0.4	2.4	2.2	3.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	36.4	21.1	10.0	22.1	1.8	0.0	2.1	2.2	4.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	17.2	27.6	5.3	3.7	14.1	0.1	3.5	6.0	22.5
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	15.4	47.7	16.5	7.6	2.3	0.0	1.5	4.5	4.4
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	16.3	13.3	5.6	4.5	33.2	0.4	3.3	7.5	15.9
Боловсрол	5.9	62.9	4.0	2.8	10.8	0.0	2.0	0.4	11.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	7.8	60.4	11.9	1.6	7.9	0.0	1.7	1.7	7.1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	10.4	46.0	9.5	8.3	10.9	0.8	4.1	1.4	8.5
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	25.5	32.4	8.8	3.3	11.7	0.2	5.7	1.1	11.2
Нийт	15.8	31.5	8.1	4.8	11.4	0.2	6.9	9.6	11.8

Дээрх үзүүлэлтийг түр ажиллагчдын хувьд авч үзвэл барилгын салбарын түр ажиллагчдын 64.3 хувь нь “Мэргэжилтэн”, “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан” чиглэлийн ажил мэргэжлийн ажиллагчид, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын 56.5 хувь нь “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан”, санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарын 57.2 хувь нь энгийн ажил мэргэжлийн ажиллагчид, мэдээлэл холбооны салбарын хувьд 59.3 хувь нь “Мэргэжилтэн” бүлгийн түр ажиллагчид байгаа бол тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын түр ажиллагчдын 73.6 хувийг “Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч”, боловсролын салбарын 78.6 хувийг “Мэргэжилтэн” бүлэгт хамаарах ажил мэргэжлийн ажиллагчид дангаараа бүрдүүлж байна.

Хүснэгт 2.6. Түр ажиллагчид, салбар, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр, хувь

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлэг									
	Менежер	Мэргэжилтэн	Техник болон туслах/дэд	Контор үйлчилгээний ажилтан	Худалдаа, үйлчилгээний ажилтан	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	Энгийн ажил мэргэжил	
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.9	6.4	15.6	0.2	3.8	31.2	4.6	8.9	28.4	
Уул уурхай, олборлолт	0.8	7.1	8.8	21.9	1.6	5.6	3.5	31.1	19.6	
Боловсруулах үйлдвэрлэл	2.2	3.7	1.7	6.2	7.4	0.0	23.3	11.7	43.7	
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.0	5.9	0.2	7.3	2.4	0.0	56.5	12.9	14.8	

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.0	1.1	6.2	0.3	3.7	5.5	4.8	41.4	37.0
Барилга	0.0	34.0	5.3	0.5	0.4	0.0	30.3	10.1	19.4
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	14.2	0.4	3.4	2.7	26.7	0.0	4.9	12.5	35.1
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	0.1	0.4	2.8	0.5	15.3	0.0	0.0	73.6	7.3
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	4.2	4.7	1.9	3.1	47.1	3.0	2.4	1.9	31.7
Мэдээлэл, холбоо	1.0	59.3	13.7	1.3	5.4	2.7	1.8	1.7	13.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	14.6	5.6	4.6	13.0	0.0	0.0	2.8	2.3	57.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.4	2.9	40.7	2.1	13.0	0.0	2.2	0.0	37.7
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.7	47.7	6.3	18.0	0.5	0.0	7.2	3.9	14.7
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.9	15.6	11.1	1.3	37.9	0.6	5.3	15.8	10.4
Боловсрол	0.4	78.6	1.4	0.8	5.5	0.0	0.0	0.3	13.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	3.0	49.6	8.6	1.9	11.5	0.0	3.4	3.7	18.1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.0	27.6	3.9	2.0	13.4	0.0	6.6	19.9	26.6
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	6.7	39.6	9.1	1.1	21.5	0.0	5.9	0.0	16.1
Нийт	4.4	21.6	5.7	4.2	13.4	1.9	11.3	12.0	25.5

Ажиллах хүчний эрэлтэд голлох нөлөө үзүүлдэг бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт ажиллагчдын 48.8 хувь нь менежер, худалдаа үйлчилгээний ажилтан, барилгын салбарын ажиллагчдын 47.3 хувийг мэргэжилтэн болон үйлдвэрлэл, барилга, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хувьд ажиллагчдын 39.7 хувийг үйлдвэрлэл, барилга, холбогдох ажил, үйлчилгээний болон энгийн ажил мэргэжлийн ажиллагчид тус тус бүрдүүлж байна.

Ажлын байран дахь шилжилт хөдөлгөөн

Сүүлийн 12 сарын хугацаанд аж ахуйн нэгж байгууллагын 36.6 хувь нь ажиллах хүчээ нэмэгдүүлсэн бөгөөд нийт шинэ ажиллагчдын 72.2 хувь нь байнгын ажиллагч бол, 65.1 хувийг сул орон тоог нөхсөн ажиллах хүчин бүрдүүлж байна. Эдгээр ажиллагчдын 42.5 хувь нь эмэгтэйчүүд байжээ.

Сүүлийн 12 сард ажилд авсан нийт ажиллагчдын 24.4 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарт харьяалагдаж байгаа бөгөөд үүний 75.5 хувь нь байнгын ажлын байр байжээ. Шинэ ажиллагчдын 14.0 хувь нь барилгын салбарт, 9.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 8.9 хувь нь боловсролын салбарт хамаарч байна. Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбар, барилга, боловсруулах үйлдвэрлэл, боловсролын салбарт сүүлийн 12 сард шинээр ажилд орсон нийт ажиллагчдын 56.5 хувь нь харьяалагдаж байна. Өөрөөр хэлбэл шинэ ажиллагчдын 2 хүн тутмын нэг нь тухайн 4 салбарын аль нэгэнд ажилд орсон байна.

Сүүлийн 12 сард харьяалагдах шинэ ажиллагчдын 24.6 хувь нь энгийн ажил мэргэжил, 22.9 хувь нь мэргэжилтэн, 13.7 хувь нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 11.6 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан гэх мэт ажил мэргэжлийн чиглэлд хамаарах ажлын байраар хангагджээ.

Мэргэжилтэн бүлэгт хамаарах ажил мэргэжлийн чиглэлээр ажилд орсон иргэд нийт ажилд орсон эмэгтэй ажиллагчдын 35.5 хувь, байнгын ажиллагчдын 26.9 хувь, нийт сул ажлын байрны

21.6 хувийг тус тус бүрдүүлж байна. Шинэ ажиллагчдад эзлэх хувиар харвал 84.8 хувь нь байнгын ажлын байр, 61.4 хувь нь сул ажлын байраар тус тус хангагджээ.

Хүснэгт 2.7. Шинэ ажиллагчдын эзлэх хувь, ажил мэргэжлийн үндсэн бүлгээр

Үндсэн бүлгийн дугаар	Ажил мэргэжлийн ангилал	Шинэ ажиллагчид			
		Нийт	Эмэгтэй	Байнгын ажлын байранд ажилд орсон	Сул ажлын байранд ажилд орсон
1	Менежер	2.6	3.3	2.8	2.7
2	Мэргэжилтэн	22.9	35.5	26.9	21.6
3	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	7.6	9.6	7.9	7.6
4	Контор үйлчилгээний ажилтан	6.5	9.3	6.4	4.5
5	Худалдаа, үйлчилгээний ажилтан	11.6	12.9	11.8	13.9
6	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	0.5	0.5	0.6	0.4
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	9.9	5.7	9.4	10.4
8	Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	13.7	1.2	14.9	12.6
9	Энгийн ажил мэргэжил	24.6	21.9	19.3	26.2
	Дүн	100	100	100	100

Шинээр авсан байнгын ажиллагчдын 19.3 хувь нь энгийн ажил мэргэжил, 14.9 хувь нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч ажил мэргэжлийн бүлэгт хамаарч байгаа бол 26.9 хувь нь мэргэжилтэн бүлгийн ажил мэргэжлийн ажиллагчид байна. Харин бүлэг тус бүрт эзлэх хувиар авч үзвэл суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч ажил мэргэжлийн бүлэгт хамаарах шинэ ажиллагчдын 78.2 хувь, техникч болон туслах, дэд мэргэжилтэн бүлгийн 75.0 хувь худалдаа үйлчилгээний ажилтан бүлгийн 73.3 хувь нь тус тус байнгын ажиллагчид байна.

Эдгээр үзүүлэлтийг эхний 20 ажил мэргэжлийн хүрээнд авч үзвэл нийт шинээр ажилд орсон ажиллагчдын 7.4 хувь нь барилгын туслах ажилтан, 6.7 хувь нь жолооч, 5.1 хувь нь үйлдвэрлэл аж ахуйн туслах ажилтан, 4.0 хувь нь гэрээт албаны харуул, хамгаалагч байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Харин ажиллагчдын 1.6 хувийг бага ангийн багш, 1.0 хувийг нягтлан бодохын ажилтан мэргэжлийн ажиллагчид эзэлж байна.

Сүүлийн 12 сард ажилд авсан нийт ачаа тээш хүргэгч ажил мэргэжлийн 89.0 хувь, хоолны газрын үйлчлэх ажилтны 84.9 хувь, гэрээт албаны харуул хамгаалалтын ажилтны 86.8 хувь, жолоочийн 84.0 хувь, зөөлөн эдлэлийн оёдолчин мэргэжлийн 82.6 хувийг тус тус сул ажлын байранд авч ажиллуулсан байна.

Шинэ ажиллагчдын ажлын байр нь ихэнх ажил мэргэжлийн хүрээнд 40-өөс дээш хувь нь сул ажлын байр байгаагаас харвал ажиллагчдын шилжилт хөдөлгөөн их байгаа ерөнхий дүр зураг харагдаж байна.

Хүснэгт 2.8. Шинэ ажиллагчдын эзлэх хувь, ажил мэргэжлээр

Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь	Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь
1	931211	Туслах ажилтан, барилгын туслах	7.4	11	911211	Цэвэрлэгч, албан тасалгааны	1.4
2	833213	Жолооч, ачааны тэрэгний	6.7	12	522112	Хүнс, гэр ахуйн бараа худалдаалагч	1.3
3	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	5.1	13	513112	Үйлчлэх ажилтан, хоолны газрын	1.3
4	541411	Харуул, гэрээт албаны	4.0	14	962918	Манаач, сахиул	1.2
5	441412	Бичиг хэргийн бусад туслах ажилтан	1.7	15	933315	Ачигч, агуулахын	1.2
6	234111	Багш, бага ангийн /мэргэжлийн/	1.6	16	832213	Жолооч, бага оврын, бүхээгт тэрэгний	1.1
7	911214	Цэвэрлэгч, албан байгууллагын	1.6	17	513111	Зөөгч	1.1
8	343411	Тогооч	1.4	18	833111	Жолооч, автобусны	1.0
9	524212	Борлуулагч	1.4	19	962113	Ачаа тээш хүргэгч	1.0
10	753311	Оёдолчин, зөөлөн эдлэлийн	1.4	20	431113	Ажилтан, нягтлан бодохын	1.0

Сүүлийн нэг жилд ажилд авсан туслах ажиллагчдаас бусад бүх ажил мэргэжил ажиллагчдын 50-аас дээш хувийг байнгын ажлын байранд авч ажиллуулжээ. Тухайлбал ажил олгогчдын сүүлийн 12 сард ажилд авсан бага ангийн багш нарын 94.8 хувь, ачаа тээш хүргэгчдийн 92.1 хувь, манаач, сахиулын ажлын 91.4 хувь, борлуулагчийн 91.0 хувь, жолооч ажил мэргэжлийн 90.3 хувийг тус тус байнгын ажилтнаар ажилд авсан байна.

Хэдийгээр сүүлийн 12 сард ажил олгогчид давхардсан тоогоор 89.1 мянган иргэнийг ажлын байраар хангаж, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгосон боловч сүүлийн 6 сарын хугацаанд 59.8 мянган ажиллагчид ямар нэг шалтгаанаар ажлаас гарсан байна. Ажлаас гарсан ажиллагчдын 62.4 хувь нь өөрийн хүсэлтээр ажлаа орхисон бол 37.6 хувь нь хөдөлмөрийн гэрээ дуусах, халагдах, цомхотголд орох гэх мэт ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөр эрхлэх боломж нь дуусгавар болжээ. Өөрийн хүсэлтээр ажлаас гарсан иргэдийн 46.8 хувь, ажил олгогчийн санаачилгаар ажлаас гарсан ажиллагчдын 41.2 хувь эмэгтэйчүүд байжээ.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар харвал нийт ажлаас гарсан иргэдийн 22.5 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбар, 12.0 хувийг барилга, 8.9 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбараас ажлаас гарсан ажиллагчид эзэлж байгаа нь эдгээр салбарт өнгөрсөн жил ажиллагчдын шилжилт хөдөлгөөн их байсныг илтгэж байна.

Ажлаас гарсан иргэдийн ажил мэргэжил сүүлийн 12 сард шинээр ажилд орсон ажиллагчдын ажил мэргэжлийн чиглэлтэй давхцаж байгаа бөгөөд тэдгээр ажил мэргэжлийн ажиллагчид ажлаас гарсантай холбоотой тухайн мэргэжлийн чиглэлийн ажиллах хүчний хэрэгцээ үүсч, шинэ ажилтнаар эрэлт хэрэгцээгээ хангасан нь тодорхой асуудал юм. Тиймээс ажлаас гарсан иргэдийг ажил мэргэжлийн чиглэлээр нь дэлгэрүүлэн тайлбарлах шаардлагагүй хэмээн үзлээ.

Судалгааны мэдээлэл цуглуулах тухайн хугацаанд ажил олгогчдод нээлттэй зарласан ажлын байр байгаа эсэхийг тодруулсан бөгөөд ААНБ-ын 23.9 хувь нь 34.4 мянган ажлын байранд ажиллагч сонгон шалгаруулж авахаар зарласан байв. Тухайлбал бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарт 10.2 мянга, боловсруулах

үйлдвэрлэлийн салбарт 3.7 мянга, барилгын салбарт 3.4 мянган нээлттэй ажлын байр байсан байна. Дээрх гурван салбарын ажиллах хүчний хэрэгцээ нийт нээлттэй ажлын байрны 50.2 хувийг бүрдүүлж байна. Нээлттэй зарласан ажлын байрны 51.9 хувь нь сул ажлын байранд ажиллагч сонгон шалгаруулж авах зар эзэлж буй бөгөөд нээлттэй ажлын байрны түвшин 5.3 хувь байна.

Хүснэгт 2.9. Нээлттэй зарлагдсан ажлын байрны түвшин, салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	Нээлттэй зарлагдсан ажлын байр			Нээлттэй ажлын байрны түвшин
	Нийт ажлын байр	Үүнээс: Сул ажлын байр	Орлуулах түвшин	
	Тоо	Тоо	Хувь	Хувь
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.7	0.3	45.9	6.9
Уул уурхай, олборлолт	0.9	0.5	60.8	2.2
Боловсруулах үйлдвэрлэл	3.7	2.1	57.3	6.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.1	0.1	53.5	0.8
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.1	0.1	59.1	1.5
Барилга	3.4	2.2	66.6	6.3
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	10.2	4.9	47.7	8.1
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	1.0	0.6	62.8	3.7
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	2.7	1.5	54.5	11.6
Мэдээлэл, холбоо	0.6	0.3	43.8	4.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0.4	0.2	48.4	2.5
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.8	0.3	34.7	7.2
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.3	0.2	14.3	5.2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2.4	1.0	44.1	9.8
Боловсрол	2.4	1.5	63.9	2.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	2.0	1.0	50.9	4.1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.3	0.2	56.7	2.6
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.6	0.9	59.8	5.0
Нийт	34.4	17.9	51.9	5.3

Нээлттэй ажлын байрны түвшинг салбарын хувьд авч үзвэл удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт 9.8, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 8.1 хувь байгаа нь өндөр хувийг үзүүлж байна. Хэдийгээр зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын хөдөлмөр эрхлэлт өнгөрсөн жилийн мөн үеэс буурсан дүр зурагтай байгаа ч нээлттэй ажлын байрны түвшин 11.6 хувь буюу бусад салбаруудтай харьцуулахад хамгийн өндөр хувийг үзүүлж байна. Мөн зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын нээлттэй ажлын байрны 54.5 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарын 47.7 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын нээлттэй ажлын байрны 44.1 хувь нь сул ажлын байр байна. Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын хувьд дээрх үзүүлэлт өндөр байхаас гадна сүүлийн 12 сард ажилд авсан ажиллагчдын сул ажлын байранд авсан түвшин /83,8 хувь/, ажиллагчид өөрийн хүсэлтээр ажлаас гарсан хувь тус тус өндөр /68.7/ байгаа нь онцгойлон анхаарал татаж байна. Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбар, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбараас бусад бүх салбарт нээлттэй ажлын байранд сул ажлын байрны эзэлж буй хэмжээ 43.0 -аас дээш хувьтай байгаа нь ажиллах хүчний цэвэр эрэлтээс илүүтэйгээр ажиллагчдын эргэлт / labor turnover/ өндөр байгааг илтгэж байна.

Хүснэгт 2.10. Шинэ болон халагдсан ажиллагчид, салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	Сүүлийн 12 сард ажилд орсон ажиллагчид			Сүүлийн 6 сард ажлаас халагдсан ажиллагчдын тоо			
	Нийт ажиллагчид	Үүнээс: Сул ажлын байранд авсан ажиллагчид	Орлуулах түвшин	Сүүлийн 6 сард ажлаас гарсан хүний тоо	Ажил олгогчийн санаачилгаар ажлаас гарсан	Өөрийн хүсэлтээр ажлаас гарсан ажиллагчид	Өөрийн хүсэлтээр ажлаас гарсан түвшин
	Тоо	Тоо	Хувь	Тоо	Тоо	Тоо	Хувь
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.6	1.0	63.8	0.6	0.2	0.4	62.5
Уул уурхай, олборлолт	4.3	2.0	47.9	3.0	2.0	1.1	34.7
Боловсруулах үйлдвэрлэл	8.2	5.9	72.2	5.4	2.0	3.4	63.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.9	0.5	59.1	0.7	0.4	0.3	44.4
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.6	0.4	75.5	0.5	0.2	0.3	56.5
Барилга	12.5	8.6	68.5	7.2	2.3	4.9	67.9
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	21.7	12.5	57.3	13.2	5.1	8.1	61.2
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	5.3	3.7	71.0	3.0	0.9	2.2	71.4
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	4.6	3.8	83.8	4.3	1.3	2.9	68.7
Мэдээлэл, холбоо	1.8	1.0	54.0	1.3	0.5	0.8	61.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.9	0.8	43.4	1.2	0.4	0.8	64.8
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.8	1.0	55.4	1.7	0.7	1.0	59.0
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2.5	1.0	39.0	1.7	0.6	1.2	67.1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	5.2	4.0	77.6	4.0	1.2	2.9	70.9
Боловсрол	7.9	5.4	68.5	5.5	2.3	3.2	57.5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	4.6	3.3	72.2	2.9	1.0	1.9	64.2
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.8	0.7	84.8	0.7	0.3	0.4	62.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2.9	2.2	76.5	2.8	1.1	1.8	62.1
Нийт	89.1	58.0	65.1	59.8	22.5	37.3	62.4

Урлаг, үзвэр, тоглоом наадамын үйл ажиллагааны салбарын шинэ ажиллагчдын ажлын байранд эзлэх сул ажлын байрны түвшин буюу нэг ажиллагчийг нөгөөгөөр орлуулсан түвшин 84.8 хувь байгаа бол тухайн салбарын ажлаас гарсан иргэдийн өөрийн хүсэлтээр ажлаас гарсан түвшин 62.1 хувь байна. Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын шинэ ажиллагчдын ажлын байранд эзлэх сул ажлын байрны түвшин 77.6 хувь, ажлаас гарсан иргэдийн өөрийн хүсэлтээр ажлаас түвшин 70.9 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын хувьд нэг ажиллагчийг нөгөөгөөр орлуулсан түвшин 76.5 хувь, өөрийн хүсэлтээр ажлаас гарсан түвшин 62.1, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хувьд дээрх үзүүлэлтүүд 72.2 хувь, 63.4 хувийн тус тус харьцаатай байна.

Ажиллагчдын ажил мэргэжлийн түвшинд нээлттэй ажлын байрны түвшин болон дээрх үзүүлэлтийг авч үзвэл зар сурталчилгаа, маркетингийн мэргэжилтэн, аялал жуулчлалын зөвлөх, аялалын газрын ажилтан, хэвлэхийн өмнөх ажиллагааны техникч, шугам зурагч, техникч, хэв цутгагч, металл боловсруулах төхөөргийн операторч, график, мультимедиа зохиомжийн дизайнер гэх мэт ажил мэргэжлийн хүрээнд дэх нээлттэй ажлын байрны түвшин, нэг ажиллагчийн нөгөөгөөр орлуулан авсан түвшин болон ажиллагч өөрийн хүсэлтээр ажлаас гарсан түвшин өндөр хувьтай байна.

Хүснэгт 2.11 Шинэ болон халагдсан ажиллагчид, ажил мэргэжлээр

ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Сүүлийн 12 сард ажилд авсан ажиллагчдын тоо			Нээлттэй ажлын байр			Нээлттэй ажлын байрны (%)	Сүүлийн 6 сард ажлаас гарсан ажиллагчид		
		Нийт	Сул ажлын байранд	Орлуулсан түвшин (%)	Нийт	Сул ажлын байр	Орлуулах түвшин (%)		Ажил олгогчийн санаачилгаар ажлаас гарсан ажиллагчид	Өөрийн хүсэлтээр ажлаас гарсан ажиллагчид	Өөрийн хүсэлтээр ажлаас гарсан түвшин (%)
7318	Давуу, арьс, бусад материалаар гар урлалын зүйлс хийгч	136	99	72.8	442	409	92.6	57.1	29	27	48.1
4229	Энэ ангилалд ороогүй хэрэглэгчийг мэдээллээр хангах бусад ажилтан	376	301	79.9	110	81	73.0	43.9	31	142	82.2
2431	Зар сурталчилгаа, маркетингийн мэргэжилтэн	443	309	69.8	425	121	28.5	38.3	45	57	55.4
4221	Аялал жуулчлалын зөвлөх, аялалын газрын ажилтан	5	5	100.0	111	5	4.7	37.7	0	14	100.0
1439	Аль нэг ангилалд ороогүй холбогдох бусад үйлчилгээний менежер	828	598	72.2	835	337	40.4	36.2	455	951	67.6
7321	Хэвлэхийн өмнөх ажиллагааны техникч	78	46	58.5	87	16	18.6	35.5	43	72	62.6
3118	Шугам зурагч, техникч	93	51	54.6	51	49	96.1	32.9	1	1	50.0
2166	График, мультимедиа зохиомжийн дизайнер	155	72	46.5	131	19	14.3	27.3	39	100	72.0
2643	Орчуулагч, хэлмэрч, бусад хэл шинжлээч	234	151	64.5	413	68	16.5	26.9	19	142	88.1
2512	Программ зохиогч	658	213	32.3	221	71	32.3	26.5	95	215	69.4
9312	Иргэний барилгын туслах ажилтан	6630	4910	74.1	1061	324	30.6	26.4	946	1136	54.6
2250	Малын эмч	376	111	29.4	457	23	5.0	25.1	22	59	72.7
4414	Бичээч холбогдох бусад ажилтан	1536	301	19.6	192	80	41.7	24.0	84	177	67.8
4311	Нягтлан бодох, данс бүртгэлийн ажилтан	1537	850	55.3	1045	329	31.4	23.8	65	150	69.7
2165	Зурагзүйч, байрзүйч	9	3	32.7	40	2	4.1	23.8	20	38	64.8

Жил бүр ажиллах хүчний эрэлт ихтэй хэмээн нэрлэгддэг орчуулагч, хэлмэрч, бусад хэл шинжлээч, иргэний барилгын туслах ажилтан, малын эмч, нягтлан бодох, данс бүртгэлийн ажилтан, зөөгч, барилга угсралтын мужаан зэрэг ажил мэргэжлийн хувьд дээрх үзүүлэлтүүд өндөр хувийг эзэлж байгаа нь тухайн ажил мэргэжлийн хүрээнд ажиллах хүчний хангагдаагүй эрэлт байгааг харуулж байна.

Шинэ ажиллагчдын ажлын байрны 65.1 хувь, нээлттэй зарлагдсан ажлын байрны 51.9 хувь нь тус тус сул ажлын байр байгаагаас харахад хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн өндөр байгааг харуулж байна. Энэ нь богино хугацааны ажиллах хүчний эрэлтэд ч нөлөөлж, ажил мэргэжлээрх эрэлт буюу эрэлттэй ажил мэргэжлийн үзүүлэлтэд ч сул ажлын байрны хүрээнд дэх ажил мэргэжлүүд өндөр хувийг эзэлдэг.

Нээлттэй зарласан ажлын байрны 28.5 хувь нь “Мэргэжилтэн”, 18.2 хувь нь “Энгийн ажил мэргэжил”, 14.2 хувь нь “Худалдаа, үйлчилгээний ажилтан”, 13.6 хувь нь “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан” гэх ажил мэргэжлийн үндсэн бүлэгт хамаарч байна.

Хүснэгт 2.12. Нээлттэй зарлагдсан ажлын байрны эзлэх хувь, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр

Үндсэн бүлгийн дугаар	Ажил мэргэжлийн ангилал	Дүнд эзлэх хувь
1	Менежер	3.5
2	Мэргэжилтэн	28.5
3	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	7.7
4	Контор үйлчилгээний ажилтан	5.5
5	Худалдаа, үйлчилгээний ажилтан	14.2
6	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	0.3
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	13.6
8	Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	8.6
9	Энгийн ажил мэргэжил	18.2
	Нийт	100.0

Ажил мэргэжил тус бүрээр авч үзвэл нийт нээлттэй ажлын байрны тус бүр 3.1 хувь нь барилгын туслах ажилтан, гэрээт албаны харуул, 3.0 хувь нь албан байгууллагын цэвэрлэгч, 2.4 хувь нь бэлэн мөнгөний ажилтан, мөн тус бүр 2.3 хувь нь борлуулагч, худалдагч, худалдааны төвийн менежер, зөөгч зэрэг ажил мэргэжлийн ажлын байр эзэлж нээлттэй ажлын байрны 20.0 гаруй хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 2.13. Нээлттэй зарлагдсан ажлын байрны эзлэх хувь, ажил мэргэжлийн ангиллаар

Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь	Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь
1	931211	Туслах ажилтан, барилгын туслах	3.1	11	712612	Сантехникч, засварчин	1.6
2	541411	Харуул, гэрээт албаны	3.1	12	343412	Тогооч, ерөнхий	1.6
3	911214	Цэвэрлэгч, албан байгууллагын	3.0	13	222111	Сувилагч, мэргэжлийн	1.6
4	431111	Ажилтан, бэлэн мөнгөний	2.4	14	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	1.5
5	524212	Борлуулагч	2.3	15	833213	Жолооч, ачааны тэрэгний	1.4

6	522112	Хүнс, гэр ахуйн бараа худалдаалагч	2.3	16	513112	Үйлчлэх ажилтан, хоолны газрын	1.4
7	143914	Худалдааны төвийн менежер	2.3	17	933315	Ачигч, агуулахын	1.3
8	513111	Зөөгч	2.3	18	234111	Багш, бага ангийн /мэргэжлийн/	1.2
9	343411	Тогооч	1.7	19	911216	Цэвэрлэгч, рестораны	1.2
10	721214	Гагнуурчин	1.7	20	832214	Жолооч, бүхээгт машины	1.2

Дээрх ажил мэргэжлүүд нь ажлаас гарсан болон шинэ ажиллагчдын ажлын байр, нээлттэй зарлагдсан ажлын байр бүрд түгээмэл тохиолдож байгаагаас харахад ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн зөвхөн эдгээр ажил мэргэжлийн ажиллагчдын хүрээнд явагдаж байна гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл салбар бүрд дээр дурьдагдсан ажил мэргэжлийн ажиллагчдын шилжилт хөдөлгөөн хамгийн өндөр байна.

Сул ажлын байрыг олон нийтэд нээлттэй зарлаад дунджаар 4 долоо хоног, хамгийн багадаа 7 хоног, хамгийн ихдээ 56 долоо хоног болж байгаа бол, цаашид үргэлжлэх хугацаа дунджаар 4.8 долоо хоног, хамгийн ихдээ 56 долоо болохоор байна. Зарим ажил олгогчдын хувьд тухайн ажлын байранд тохирох ажилтныг авах хүртэл үргэлжлүүлэн зарласаар байна.

Ажлын байрны ур чадварын шаардлагыг харвал ажлын туршлага, ачаалал даах чадварын түлхүү шаардахаас гадна ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалан гадаад хэлний мэдлэг, мэргэжлийн зэрэгтэй байхыг илүүд үзсэн байна.

2.2. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЭРЭЛТ

Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн чиг хандлага, богино хугацааны эрэлтийн төлөв байдлын талаарх мэдээллийг хүргэх зорилгын хүрээнд хийгддэг энэхүү судалгаагаар 2020 онд хөдөлмөрийн зах зээлд эдийн засгийн 18 салбарын хүрээнд үүсэх ажиллах хүчний эрэлтийн мэдээллийг тодрууллаа.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгааны судлах гол асуудал нь ажлын байрны өсөлтийн талаарх ажил олгогчдын төсөөлөл юм. Энэхүү төсөөлөл нь эдийн засгийн салбар, байршил болон цаг хугацаанаас хамааран харилцан адилгүй байдаг хэдий ч жил бүрийн ажиллах хүчний эрэлтийг харахад тодорхой хэд хэдэн салбарын ажиллах хүчний эрэлт тогтмол эерэг өөрчлөлтийг үзүүлж, ажиллах хүчний шингээлт өндөртэй байхаар байна. Эдгээр салбарууд нь жил бүрийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэхэд голлон нөлөөлдөг. Харин зарим салбарын хувьд тухайн салбарын онцлог, цар хүрээнээс хамааран ажиллах хүчний эрэлт бага байдаг бөгөөд энэ нь жил бүрийн судалгааны дүнгээс харагддаг. Тухайлбал ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, цахилгаан хий, агааржуулалтын үйл ажиллагааны салбаруудад ажиллах хүчний эрэлт хамгийн бага байдаг. Үүний нэгэн адил ажиллах хүчний эрэлт бүс нутгаар харилцан адилгүй байдгийг олон жилийн судалгааны дүнгээс харж болно. Орон нутагт нийслэлтэй харьцуулахад илүү бага ажиллах хүчний эрэлт бий болох төлөвтэй байдаг.

Судалгааны үндсэн үр дүнг өмнөх жилийн судалгааны нэгэн адил түүврийн эх олонлогт тархаан тооцсон болно. Хөдөлмөрийн зах зээлийн ажиллах хүчний эрэлтийг оны эхний ба сүүлийн хагас жилээр ангилан, ажлын байрны хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлээр задлан харууллаа.

Энэ удаагийн Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгааны дүнгээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 31.8 хувь нь шинэ болон сул ажлын байранд ажилтан авахаар төлөвлөсөн нь өмнөх жилийнхээс 4.2 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Бүс нутгийн хувьд Баруун бүсийн 39.5 хувь, Төвийн бүсийн 32.6 хувь, Зүүн бүсийн 30.5 хувь, Хангайн бүсийн ААНБ-ын 27.3 хувь нь тус тус ажилтан авахаар төлөвлөсөн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад бүх бүсд ажиллах хүчний эрэлт өсөх хүлээлттэй байгааг харуулж байна. Улаанбаатар хотын ажил олгогчдын 31.9 хувь нь ирэх онд ажиллах хүчээ нэмэгдүүлэх хэрэгцээ байгааг илэрхийлсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 0.9 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Зураг 2.5. 2019 онд ААНБ-ууд шинээр ажилтан авах эсэх, бүсээр, хувиар



Энэ удаагийн судалгаагаар 2020 онд хөдөлмөрийн зах зээлд 72.7 мянган ажиллах хүчний эрэлт, хэрэгцээ бий болохоор байна. Энэ нь ажиллах хүчний эрэлт өнгөрсөн оны судалгааны үр

дүнгээс 4.8 хувиар өсөх төлөвтэй бөгөөд 2020 онд ажил олгогчид эерэг хүлээлтэй байгааг харуулж байна.

Ажиллах хүчний эрэлтийн 81.6 хувь нь 2020 оны эхний хагаст, үлдсэн 18.4 хувь нь оны сүүлийн хагас жилд бий болох төлөвтэй байна.

2.2.1. ОНЫ ЭХНИЙ 6 САРЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЭРЭЛТ /2020.01-2020.06/

Энэ онд хөдөлмөрийн зах зээлд бий болох ажиллах хүчний нийт эрэлтийн 59.4 мянга буюу 81.6 хувь нь оны эхний хагас /эхний 6 сард/-т бий болох төлөвтэй байна.

Оны эхний хагаст бий болох ажиллах хүчний эрэлтийг салбараар авч үзвэл бөөний болон жижиглэн худалдааны салбарт 10.8 мянга буюу оны эхний хагаст бий болох ажиллах хүчний эрэлтийн 23.7 хувь, барилгын салбарт 7.9 мянга буюу 22.5 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 5.0 мянга буюу 10.0 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт 2.2 мянга буюу 5.2 хувь, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт 2.9 мянга буюу 5.0 хувь нь тус тус бий болох төлөвтэй байна. Харин цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж, урлаг, үзвэр, тоглоом наадам, санхүү, даатгал, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт ажиллах хүчний эрэлт бага байхаар байна.

Оны эхний хагас жилд бий болохоор хүлээгдэж буй ажиллах хүчний эрэлтийн 48.2 мянга буюу 81.1 хувь нь байнгын ажлын байр байна. Мөн эрэлтийн 72.4 хувь нь Улаанбаатар хотод, 11.6 хувь нь Хангайн бүсэд бий болох дүр зураг гарчээ.

Зураг 2.6. 2020 оны эхний 6 сарын ажиллах хүчний эрэлт, ЭЗҮА-ны салбарын эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, хувиар



2.2.2. ОНЫ СҮҮЛИЙН 6 САРЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЭРЭЛТ /2020.07-2020.12/

Энэ оны сүүлийн хагаст улсын хэмжээнд 13.4 мянган ажлын байр буюу ажиллах хүчний нийт эрэлтийн 18.4 хувь нь бий болохоор байна. Ажиллах хүчний сүүлийн хагас жилийн эрэлтийн хүрээнд бий болох ажлын байрны 82.2 хувь нь байнгын, үлдсэн бага хувь нь түр ажлын байр байна.

Байршлаар харвал оны сүүлийн хагаст бий болох ажиллах хүчний эрэлтийн 80.3 хувь нь Улаанбаатар хотод, 8.0 хувь нь Хангайн бүсэд бий болох хүлээлттэй байна.

Зураг 2.7. 2020 оны сүүлийн 6 сарын ажиллах хүчний эрэлт, ЭЗҮА-ны салбарын ангилал, хувиар



Оны сүүлийн хагаст бий болох ажиллах хүчний эрэлтийн 19.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарт, 11.3 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 10.0 хувь нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт, 9.3 хувь нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт, 8.9 хувь нь барилгын салбарт бий болох төсөөлөлтэй байна. Эдгээр нь сүүлийн 6 сарын нийт эрэлтийн 58.7 хувийг бүрдүүлж байна.

2020 оны сүүлийн хагаст бий болох ажиллах хүчний эрэлт өмнөх оны сүүлийн хагасын ажиллах хүчний эрэлттэй харьцуулахад 12.1 хувиар буурах төлөвтэй байгаа бол оны эхний хагаст бий болох ажиллах хүчний эрэлт 9.5 хувиар нэмэгдэх хандлагатай байна.

2.2.3. 2020 ОНЫ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ НИЙТ ЭРЭЛТ

Ажиллах хүчний эрэлтийн жилийн мэдээлэл нь илүү их ач холбогдолтой бөгөөд улирлын чанартай онцлогийг харах боломжтой юм.

Улсын хэмжээнд 2020 онд 72.7 мянган ажлын байр бий болох ба өмнөх оноос 4.8 хувиар өсөх хандлагатай байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн шингээлт нэмэгдэх төлөв байдлыг харуулж байна. Энэхүү эрэлт нь нийт ажиллагчдын тоог 6.3³ хувиар өсгөх боломж олгох юм.

Энэ /2020 он/ жилийн хугацаанд ажиллах хүчний эрэлт хамгийн их байх салбар нь бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэл, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарууд байгаа нь өмнөх жилийн хандлагыг давтсан үзүүлэлт болж байна. Гэхдээ барилга болон, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажиллах хүчний эрэлт өмнөх оны үр дүнгээс буурахаар харагдаж байна. Тухайлбал, барилгын салбарт 14.5 мянган ажиллах хүчний эрэлт бий болох нь нийт эрэлтийн 20.0 хувийг дангаараа бүрдүүлж байгаа ч өмнөх жилийн судалгааны үр дүнгээс 17.9 хувиар буурсан үзүүлэлт юм. Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 7.4 мянга буюу нийт эрэлтийн 10.2 хувь бий болох төсөөлөлтэй байгаа нь өмнөх онтой харьцуулахад 27.7 хувиар буурах төлөвтэй байна. Хэдийгээр дээрх салбаруудын ажиллах хүчний эрэлт өмнөх оноос буурах хэдий ч хөдөлмөрийн зах зээлд голлох эерэг нөлөөг үзүүлэх салбарууд хэвээр байна.

³ ҮСХ, 2019 оны III улирлын ажиллагчдын тоонд харьцуулсан утга

Харин бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбар, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын ажиллах хүчний эрэлт өмнөх оноос өсөх хандлагатай байна.

Ажиллах хүчний эрэлт өндөр байх бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын эрэлт 2020 оны ажиллах хүчний эрэлтийн 53.1 хувийг бүрдүүлж байна.

Зураг 2.8. 2020 оны ажиллах хүчний эрэлт, салбарын ангилал, хувиар




Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт 6.1 хувь, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт 5.5 хувь, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт 5.0 хувь, уул уурхай, олборлолтын салбарт 4.1 хувь, боловсролын салбарт 3.8 хувь, ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт 3.1 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 3.1 хувь нь бий болохоор байна.

Харин ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамжийн үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, урлаг үзвэр, тоглоом наадам, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбаруудад ажиллах хүчний эрэлт хамгийн бага байхаар байна. Эдгээр салбарууд нийлээд 5.7 мянган ажлын байр буюу нийт эрэлтийн 7.9 хувийг эзэлж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаас үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын эрэлт өмнөх оноос 25.8 хувь, боловсролын салбарын эрэлт 38.7 хувь, тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын эрэлт 28.7 хувь, урлаг, үзвэр, тоглоом наадам салбарын эрэлт 22.8 хувь, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын эрэлт 4.8 хувь, мэдээлэл, холбооны салбарын эрэлт 1.1 хувиар тус тус буурах хандлагатай байна.

Хэдийгээр зарим салбарын ажиллах хүчний эрэлт бага байгаа ч өмнөх онтой харьцуулахад өсөх төсөөлөлтэй байна. Тухайлбал боловсролын салбарын эрэлт ажиллах хүчний эрэлт өмнөх жилийн эрэлтээс 62.6 хувь, уул уурхай, олборлолтын салбарын эрэлт 35.5 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын эрэлт 25.3 хувь, ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын эрэлт 21.2 хувиар тус тус өсөхөөр тооцоологдлоо. Мөн хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбар, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын ажиллах хүчний эрэлт 2 дахин өсөх төлөвтэй байна.

Зураг 2.9. Ажиллагчдын тоо болон ажиллах хүчний эрэлт, салбарын ангиллаар, мянган хүн



Хүлээгдэж буй ажиллах хүчний эрэлтийг тухайн салбарын ажиллагчдын тоо⁴ -той харьцуулан авч үзвэл салбарын ажиллах хүчний эрэлт нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын ажиллагчдын 19.5 хувь, барилгын салбарын ажиллагчдын 16.3 хувь, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарын 13.3 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын ажиллагчдын 11.2 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарын ажиллагчдын 10.9 хувьтай тус тус тэнцүү байна.

Энэ /2020/ онд хөдөлмөрийн зах зээлд бий болох ажиллах хүчний эрэлтэд өмнөх жилүүдийн адил улирлын нөлөө ажиглагдсаар байна. Тухайлбал, 2020 оны эхний хагаст ажиллах хүчний нийт эрэлтийн 81.6 хувь нь бий болох нь сүүлийн 6 сарын ажиллах хүчний эрэлтээс 4.4 дахин их байгаа юм. Энэ нь улирлын чанартай, түр ажиллах хүчний эрэлтээс хамаардаг болохыг жил бүрийн судалгааны дүнгээс харж болно. Тухайлбал 2020 онд бий болох түр ажиллах хүчний эрэлтийн 82.5 хувь нь эхний хагас жилд бий болох төсөөлөлтэй байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар тус бүрээр авч үзвэл ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарт бий болох нийт эрэлтийн 96.8 хувь, барилгын салбар болон урлаг, үзвэр, тоглоом наадам салбарын эрэлт тус бүрийн 91.8 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын эрэлтийн 84.8 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарын 84.5 хувь, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарын 82.1 хувь, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын 82.0 хувь, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын эрэлтийн 81.7 хувь нь тус тус оны эхний хагас жилд бий болох төлөвтэй байгаа нь онцлог юм.

⁴ - ҮСХ, 2019 оны III улирлын ажиллагчдын тоо


Хүснэгт 2.14. 2020 оны ажиллах хүчний эрэлт, салбар, хугацаагаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажиллах хүчний нийт эрэлт /мян.хүн/	Эхний 6 сар		Сүүлийн 6 сар	
		/мян.хүн/	Хувь	/мян.хүн/	Хувь
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	2.3	1.8	79.3	0.5	20.7
Уул уурхай, олборлолт	3.0	2.1	69.9	0.9	30.1
Боловсруулах үйлдвэрлэл	7.4	5.9	79.6	1.5	20.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.7	0.5	79.4	0.1	20.6
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	1.5	1.4	96.8	0.05	3.2
Барилга	14.5	13.3	91.8	1.2	8.2
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	16.7	14.1	84.5	2.6	15.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2.0	1.4	71.5	0.6	28.5
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	4.0	2.7	68.7	1.2	31.3
Мэдээлэл, холбоо	1.6	1.2	75.2	0.4	24.8
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.5	1.0	67.1	0.5	32.9
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.1	0.9	82.0	0.2	18.0
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2.5	2.0	82.1	0.4	17.9
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	4.4	3.1	69.9	1.3	30.1
Боловсрол	2.8	2.0	72.2	0.8	27.8
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	3.6	2.9	81.7	0.7	18.3
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.9	0.8	91.8	0.1	8.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2.3	1.9	84.8	0.3	15.2
Нийт	72.7	59.3	81.6	13.4	18.4

Мөн ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан, хий, уур, агааржуулалт, тээвэр, агуулахын үйл ажиллагаа, мэдээлэл, холбоо, боловсрол, уул уурхай, олборлолт, боловсруулах үйлдвэрлэл, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ гэх мэт салбарын ажиллах хүчний эрэлтийн 69-80 хувь нь оны эхний хагаст бий болохоор байна.

2020 онд хөдөлмөрийн зах зээлд бий болох ажиллах хүчний эрэлтийг байршлаар тодруулбал, нийт эрэлтийн 68.7 хувь буюу 49.9 мянга нь Улаанбаатар хотод, 12.1 хувь буюу 8.8 мянга нь Хангайн бүсэд, 11.0 хувь буюу 8.0 мянга нь Төвийн бүсэд, үлдсэн хувь нь Баруун болон Зүүн бүсэд бий болох төлөвтэй байна.

Зураг 2.10. 2020 оны ажиллах хүчний эрэлтийн хувь, бүсээр



Улаанбаатар хотод хамгийн олон тооны ажлын байр буюу 50.0 мянган ажиллах хүчний эрэлт бий болох төлөвтэй байна. Үүний 59.3 хувь нь шинэ ажлын байранд ажиллах хүч авах эрэлт эзэлж байна. Улаанбаатар хотод бий болох ажиллах хүчний эрэлтэд бөөний болон жижиглэн худалдааны салбар, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд голлох эерэг нөлөө үзүүлсэн хэвээр байна. Тухайлбал Улаанбаатар хотод бий болох ажиллах хүчний эрэлтийн 20.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 19.6 хувь нь , барилгын салбарт, 9.4 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үүсэх төлөвтэй байна.

Хэдийгээр Нийслэлд бий болох ажиллах хүчний эрэлтэд бага хувийг эзэлж байгаа хэдий ч тухайн салбарын ажиллах хүчний эрэлтэд Улаанбаатар хотод бий болох ажиллах хүчний эрэлт өндөр байх салбарууд ч байна. Тодруулбал хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын эрэлтийн 94.8 хувь, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын 94.1 хувь, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын ажиллах хүчний эрэлтийн 91.5 хувь нь Улаанбаатар хотод бий болж ажиллах хүчний өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Түүнчлэн үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын ажиллах хүчний эрэлтийн 88.2 хувь, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарын 87.5 хувь, мэдээлэл, холбооны салбарын 86.4 хувь, боловсролын салбарын эрэлтийн 84.5 хувь, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын эрэлтийн 83.6 хувь, урлаг, үзвэр, тоглоом наадам салбарын 83.4 хувь, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын 82.5 хувь, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын эрэлтийн 82.0 хувь нь тус тус Улаанбаатар хотод бий болохоор байна.

2020 оны хүлээгдэж буй ажиллах хүчний нийт эрэлтийн 31.4 хувь нь орон нутагт бий болох бөгөөд үүний 60.9 хувь нь шинэ ажлын байр байгаа нь орон нутгийн хөдөлмөрийн зах зээл мөн хэмжээгээр тэлэх боломжтойг харуулж болно. Орон нутгийн ажиллах хүчний эрэлтэд дараах эдийн засгийн салбарууд гол нөлөөг үзүүлж байна. Тухайлбал, бөөний болон жижиглэн худалдааны салбарт орон нутгийн ажиллах хүчний эрэлтийн 30.4 хувь, барилгын салбарт 21.0 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 12.4 хувь нь тус тус нь бий болох төлөвтэй байна.

Харин салбарт эзлэх ажиллах хүчний эрэлтээр харвал хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын нийт эрэлтийн 44.2 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарын 34.6 хувь, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарын эрэлтийн 30.9 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын ажиллах хүчний эрэлтийн 30.5 хувь нь тус тус орон нутагт бий болох төлөвтэй байна.

Бүсээр авч үзвэл Хангай болон Төвийн бүсэд ажиллах хүчний эрэлт бусад бүсээс өндөр байх ба 16.8 мянган шинэ болон сул ажлын байр бий болохоор байна. Ялангуяа Хангайн бүсэд

8.8 мянган ажиллах хүчний эрэлт үүсэх төлөвтэй бөгөөд тухайн бүс нутгийн ажиллах хүчний эрэлтэд мөн боловсруулах үйлдвэрлэл, бөөний болон жижиглэн худалдаа, барилгын салбарын эрэлт голлон нөлөөлөхөөр харагдаж байна.


Төвийн бүс нутагт барилга, бөөний болон жижиглэн худалдааны салбар, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын ажиллах хүчний эрэлт илүү өндөр хувийг эзэлж байна.

Хэдийгээр Баруун болон Зүүн бүс нутаг нь бусад бүстэй харьцуулахад ажиллах хүчний эрэлт харьцангуй бага байх төлөвтэй байгаа ч 6.0 мянган шинэ болон сул ажлын байр бий болох хандлагатай байна.

Баруун бүсэд бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажиллах хүчний эрэлт өндөр хувийг эзэлж байна. Тухайлбал, тус салбаруудад тухайн бүс нутгийн ажиллах хүчний эрэлтийн 76.5 хувь нь бий болох төлөвтэй байна.

Зүүн бүсэд ажиллах хүчний эрэлт бага байхаар тооцоологдсон ч тухайн бүсийн ажиллах хүчний эрэлтэд бөөний болон жижиглэн худалдааны салбар, боловсруулах үйлдвэрлэл, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарын ажиллах хүчний эрэлт илүү нөлөө үзүүлэхээр байгаа бөгөөд бүс нутгийн ажиллах хүчний нийт эрэлтийн 47.5 хувийг дээрх салбаруудын ажиллах хүчний эрэлт эзэлж байна. Харин энэ бүс нутагт цахилгаан, хий, уур, агааржуулалт, урлаг, үзвэр, тоглоом наадам, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарт ажиллах хүчний эрэлт хамгийн бага байх бол тээвэр, агуулахын үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын хувьд ажиллах хүчний эрэлт төдийлөн бий болохгүй төлөв харагдаж байна. Бусад бүсүүдэд ч дээрх салбаруудын ажиллах хүчний эрэлт бага байх төлөвтэй байна.

Зураг 2.11. Ажиллах хүчний эрэлтийн эзлэх хувь, ААНБ-ын өмчийн хэлбэр, ажлын байрны төрлөөр



Ажиллах хүчний нийт эрэлтийн 87.1 хувь нь хувийн хэвшлийн ААНБ-д, 10.6 хувь нь төрийн үйлчилгээний байгууллагад, үлдсэн хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-уудад бий болохоор байна.

Энэ нь тухайн жилийн ажиллах хүчний нийт эрэлтийн 10 ажлын байрны 9 нь хувийн хэвшлийн ААНБ-д бий болохоор байгааг харуулж байна.

Хөдөлмөрийн зэх зээлд 2020 онд бий болох ажиллах хүчний эрэлтийг ажлын байрны хэлбэрээр дэлгэрүүлэн авч үзвэл нийт эрэлтийн 81.3 хувь буюу 59.2 мянга нь байнгын ажиллах хүчний эрэлт байна. Өөрөөр хэлбэл ирэх онд бий болохоор хүлээгдэж буй 10 ажлын байр тутмын 8 нь байнгын ажлын байр байна. Энэ өмнөх оны үр дүнгээс 11.2 пунктээр өсөх үзүүлэлттэй байна. Харин 18.7 хувь буюу 13.6 мянга нь түр ажлын байр байх бөгөөд энэ нь өмнөх оныхоос буурах төлөвтэй байна.

2020 онд бий болох 59.2 мянган байнгын ажиллах хүчний эрэлтийн 86.9 хувь буюу 51.4 мянга нь хувийн өмчийн ААНБ-уудад, 10.9 хувь буюу 6.5 мянга нь төрийн өмчийн, үлдсэн 2.2 хувь нь буюу 1.3 мянга нь хувийн хамтарсан болон гадаад улсын хөрөнгө оруулалттай ААНБ-д бий

болох тооцоо гарсан. Түр ажлын байрны хувьд ч 88.2 хувь нь хувийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагад бий болж үлдсэн хувь нь бусад өмчийн хэлбэрийн ажил олгогчдод бий болох төлөв байна.

Байнгын ажлын байрны 81.4 хувь нь, түр ажлын байрны 82.5 хувь нь оны эхний хагас жилийн хугацаанд бий болох хандлагатай байна. Байнгын ажиллах хүчний эрэлтэд гол нөлөө үзүүлж буй салбар нь бөөний болон жижиглэн худалдаа болон барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд юм. Тухайн салбаруудын байнгын ажиллах хүчний эрэлт нийт байнгын ажлын байрны эрэлтийн 50.4 хувийг, түр ажиллах хүчний нийт эрэлтийн 65.1 хувийг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 2.15. Ажиллах хүчний эрэлт, ажлын байрны хэлбэр, салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажиллах хүчний эрэлт /мян.хүн/		Эзлэх хувь	
	Байнгын	Түр	Байнгын	Түр
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.5	0.7	2.6	5.2
Уул уурхай, олборлолт	2.7	0.3	4.6	1.9
Боловсруулах үйлдвэрлэл	6.2	1.3	10.4	9.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.3	0.4	0.5	2.8
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	1.5	0.0	2.5	0.0
Барилга	8.9	5.6	15.1	41.2
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	14.7	2.0	24.8	14.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.8	0.2	3.1	1.3
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	3.5	0.5	5.9	3.5
Мэдээлэл, холбоо	1.0	0.6	1.7	4.4
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.5	0.0	2.6	0.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.9	0.2	1.6	1.5
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2.3	0.2	3.9	1.5
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	3.2	1.2	5.4	9.1
Боловсрол	2.6	0.2	4.3	1.5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	3.4	0.2	5.8	1.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.8	0.1	1.4	0.5
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2.2	0.0	3.8	0.2
Нийт	59.2	13.6	100.0	100.0

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, байнгын ажилтан авах хэрэгцээ ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбар, үйлчилгээний бусад үйл ажиллагаа, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, боловсрол, урлаг, үзвэр, тоглоом наадам, уул уурхай, олборлолтын салбаруудад өндөр хувьтай байна. Тухайлбал, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын нийт эрэлтийн 99.8 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын эрэлтийн 98.9 хувь, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын 98.3 хувийг бүрдүүлж байна. Түүнчлэн барилга болон цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбар, мэдээлэл, холбоо, ХАА, ойн аж ахуйн салбараас бусад салбаруудын ажиллах хүчний эрэлтийн 80.0-аас дээш хувийг байнгын ажиллах хүчний эрэлт эзэлж байна. Тухайлбал хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, боловсрол, урлаг, үзвэр, тоглоом наадам, уул уурхай, олборлолт,

мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, боловсролын салбарын ажиллах хүчний эрэлтийн 91-94 хувийг, бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар, боловсруулах үйлдвэрлэл, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын эрэлтийн 81-88 хувийг тус тус байнгын ажиллах хүчний эрэлт эзэлж байна.

Хэдийгээр энэ оны түр ажиллах хүчний эрэлт өмнөх жилийнхээс буурах ч ажиллах хүчний эрэлтэд багагүй хувийг эзэлсэн хэвээр байна. Түр ажиллах хүчний нийт эрэлтэд эзлэх хувиар харвал барилгын салбарт 41.2 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарт 14.6 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 9.2 хувь нь харьяалагдаж байна. Харин эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын хувьд цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын 56.3 хувь, барилгын салбарын 38.5 хувь, мэдээлэл, холбооны салбар 36.6 хувь, ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарын эрэлтийн 31.2 хувь нь түр ажиллах хүчний эрэлт байна.

Хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчний эрэлтийг үүсгэж буй ажлын байрыг төрлөөр нь авч үзвэл 2020 онд бий болох нийт ажиллах хүчний эрэлтийн 43.5 мянга буюу 59.8 хувь нь шинэ ажлын байранд ажилтан авах эрэлт байгаа нь хөдөлмөрийн зах зээл энэ хэмжээгээр тэлэх боломжтойг харуулж байна. Харин нийт эрэлтийн 29.2 мянга буюу 40.2 хувь нь сул ажлын байр байна.


Хүснэгт 2.16. Ажиллах хүчний эрэлт, салбараар, ажлын байрны төрлөөр

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажиллах хүчний эрэлт /мян.хүн/			Эзлэх хувь	
	Нийт	Шинэ	Сул	Шинэ	Сул
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	2.3	1.3	0.9	3.1	3.1
Уул уурхай, олборлолт	3.0	1.5	1.4	3.5	4.9
Боловсруулах үйлдвэрлэл	7.4	4.3	3.1	9.9	10.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.7	0.1	0.6	0.2	2.0
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	1.5	1.4	0.1	3.2	0.3
Барилга	14.5	9.4	5.1	21.6	17.6
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	16.7	10.4	6.3	23.9	21.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2.0	0.7	1.3	1.5	4.6
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	4.0	1.9	2.1	4.3	7.2
Мэдээлэл, холбоо	1.6	1.0	0.6	2.3	2.1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.5	0.9	0.6	2.2	2.1
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.1	0.7	0.4	1.6	1.5
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2.5	1.6	0.9	3.7	3.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	4.4	2.5	1.9	5.9	6.5
Боловсрол	2.8	1.8	1.0	4.1	3.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	3.6	2.4	1.2	5.5	4.2
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.9	0.4	0.6	0.8	1.9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2.3	1.2	1.0	2.8	3.5
Нийт	72.7	43.5	29.2	100.0	100.0

Ажиллах хүчний эрэлтийн хүрээнд бий болох шинэ ажлын байрны 23.9 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 21.6 хувь нь барилгын салбарт, 9.9 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт тус тус бий болох бол сул ажлын байрны ажиллах хүчний эрэлтийн 49.8 хувь нь мөн эдгээр салбаруудад бий болохоор харагдаж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын хувьд ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагааны салбарын эрэлтийн 93.6 хувийг шинэ ажлын байрны ажиллах хүчний эрэлт дангаараа бүрдүүлж байгаа бол мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарын ажиллах хүчний эрэлтийн 65.1 хувь, боловсролын салбарын 64.8 хувь, барилгын салбарын 64.7 хувь, мэдээлэл, холбооны салбарын 62.7 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарын 62.3 хувь, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын эрэлтийн 61.3 хувь нь шинэ ажиллах хүчний эрэлт байх төлөвтэй байна. Энэ нь эдгээр салбаруудын ажиллагчдын тоо мөн хэмжээгээр өсөх боломжтойг харуулж байна. Дээрх салбаруудаас гадна ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар, уул уурхай, олборлолт, боловсруулах үйлдвэрлэл, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбаруудын ажиллах хүчний эрэлтийн 50.0-60.0 хувийг шинэ ажиллах хүчний эрэлт эзэлж байна. Харин сул ажлын байрны ажиллах хүчний эрэлтийн хувьд цахилгаан, хий, уур, агааржуулалт, урлаг, үзвэр, тоглоом наадам, тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбаруудад эрэлт хамгийн өндөр байна. Тухайлбал, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын эрэлтийн 88.3 хувь, тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын эрэлтийн 67.4 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 2.12. Ажиллах хүчний эрэлтийн эзлэх хувь, ажлын байрны төрөл, өмчийн хэлбэрээр



Шинэ ажлын байрны 89.3 хувь, сул ажлын байрны 83.9 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад бий болох хүлээлттэй байна. Өмчийн хэлбэрт эзлэх хувийн жингээр харвал төрийн өмчийн ажил олгогчдод үүсэх ажиллах хүчний эрэлтийн 51.6 хувь, хувийн өмчийн ажил олгогчдын 61.3 хувь, гадаад улсын хөрөнгө оруулалттай ажил олгогчдод бий болох ажиллах хүчний эрэлтийн 40.0 хувь нь шинэ ажлын байр байна.

Өнгөрсөн оны судалгааны үр дүнгээр сул ажлын байрыг нөхөх ажиллах хүчний эрэлт 24.1 мянга байсан бол энэ удаагийн судалгааны үр дүнгээр 29.2 мянга байх тооцоо гарсан. Жил бүрийн судалгааны үр дүнгээр сул ажлын байрыг нөхөх зорилготой ажиллах хүчний эрэлт багагүй хувийг эзэлсэн хэвээр байна. Энэ нь нэг талаас ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн их байгааг илтгэж байна.

Ажил олгогчдын үзэж буйгаар сул ажлын байр бий болж буй шалтгааныг хөдөлмөрийн харилцаанд оролцогч иргэний хувийн зохион байгуулалт, хандлага ёс зүйтэй холбон тайлбарладаг хэвээр байна. Өөрөөр хэлбэл хувь хүний хариуцлагагүй байдал, ажил хөдөлмөр эрхлэх хүсэл, эрмэлзлэлгүй байгаа нь голлох шалтгаан болж байгааг дурьджээ. Тухайлбал ажил олгогчдын хамгийн түгээмэл нэрлэсэн шалтгаан нь ажиллагч өөрийн хүсэлтээр ажлаас гарах, тодорхойгүй шалтгаанаар ажлаа орхих, тогтвор суурьшилтай ажиллахгүй байх үзэгдэл бөгөөд эдгээр нь сул ажлын байр бий болох шалтгааны 60.0 хувийг эзэлж байна.

Зураг 2.13. Сул ажлын байр бий болсон шалтгаан, хувиар



Мөн хуулийн дагуу тэтгэвэр, тэтгэмжид хамрагдах, жирэмсний амралтаа авах тохиолдол нь 19.3 хувийг бүрдүүлж байгаа бол ажил олгогчийн санаачилгаар буюу ажиллагч халагдах тохиолдол нийт шалтгааны 7.1 хувийг эзэлж байна.

Ажил олгогчид ажиллагчдаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор нийгмийн асуудалд нь анхаарч байгууллагын зүгээс тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлдэг бөгөөд нийт авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд эзлэх хувиар харвал 33.8 хувийг ажиллагчдын цалин, урамшууллыг нэмэх, 23.5 хувийг мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх сургалтад хамруулах арга хэмжээ эзэлж байгаа бол 23.3 хувь нь одоогоор ямар нэг ажил хийж амжаагүй байна гэсэн хариулт эзэлж байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгааны үндсэн үр дүнгийн нэг нь ХЗЗ-ийн эрэлтийг ажил мэргэжлийн бүлгээрх тооцоолол байдаг. Энэхүү мэдээлэл хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрийн талаарх чухал мэдээлэл юм.

2020 оны ажиллах хүчний эрэлтийг ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр үзвэл ажиллах хүчний нийт эрэлтийн 25.2 хувийг “Энгийн ажил мэргэжил” буюу IX бүлгийн, 23.8 хувийг “Мэргэжилтэн” буюу II бүлгийн ажил мэргэжил, 14.5 хувийг “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан” буюу VII бүлгийн ажил мэргэжил, 12.2 хувийг “Худалдаа, үйлчилгээний ажилтан” буюу V бүлгийн ажил мэргэжлийн эрэлт тус тус эзэлж байна. “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан” бүлэгт хамаарах ажил мэргэжлийн эрэлтийн ажиллах хүчний нийт эрэлтэд эзлэх хувийн жин өмнөх оныхоос буурсан бол “Энгийн ажил мэргэжил” болон “Мэргэжилтэн” гэсэн үндсэн бүлэгт хамаарах ажил мэргэжлийн ажиллах хүчний эрэлт өсөх дүр зураг харагдаж байна.

Хүснэгт 2.14. Ажиллах хүчний эрэлт, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлэг, хувиар

Үндсэн бүлгийн дугаар	Ажил мэргэжлийн ангилал	Дүнд эзлэх хувь
1	Менежер	3.1
2	Мэргэжилтэн	23.8
3	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	7.5
4	Контор үйлчилгээний ажилтан	4.1
5	Худалдаа, үйлчилгээний ажилтан	12.2

6	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	0.8
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	14.5
8	Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	8.8
9	Энгийн ажил мэргэжил	25.2
	Нийт	100.0

Судалгааны түүврийн хэмжээний боломжид тулгуурлан хамгийн их эрэлттэй ажил мэргэжлийг жил бүр тодорхойлдог бөгөөд 2020 онд дараах 20 ажил мэргэжил хамгийн эрэлттэй байх ба нийт ажиллах хүчний эрэлтийн 45.7 хувийг эзэлж байна.

Ажил мэргэжлийн хувьд тухайн жилд ажиллах хүчний эрэлт өндөр байх салбарт харьяалагдах ажил мэргэжлээрх эрэлт илүү өндөр байх төлөвтэй байна. Тухайлбал, ажиллах хүчний нийт эрэлтийн 11.0 хувийг барилгын туслах ажилтан, 1.2 хувийг сантехникч, хоолой засварчин, тус бүр 1.1 хувийг цахилгаанчин, гагнуурчин, сантехникч, хоолой угсрагч зэрэг барилгын салбарын ажил мэргэжлийн эрэлт эзэлж байна. Түүнчлэн үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан, гэрээт албаны харуул, мах махан бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан, дэлгүүрийн кассчин, албан байгууллагын цэвэрлэгч зэрэг тусгайлсан мэргэжил шаардахгүй энгийн ажил мэргэжил, борлуулагч, тогооч, зөөгч, ачааны болон бага оврийн суудлын машин, хогны машины жолооч зэрэг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэдэг ажил мэргэжлийн эрэлт давамгайлсан хэвээр байна.

Хүснэгт 2.15. Эрэлттэй ажил мэргэжил, хувиар

Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь	Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь
1	931211	Туслах ажилтан, барилгын туслах	11.0	11	215111	Инженер, цахилгааны	1.4
2	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	4.8	12	833215	Жолооч, хогны машины	1.3
3	524212	Борлуулагч	3.9	13	751111	Мах махан бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан	1.3
4	911214	Цэвэрлэгч, албан байгууллагын	3.1	14	523011	Дэлгүүрийн кассчин	1.3
5	343412	Тогооч, ерөнхий	2.2	15	712612	Сантехникч, хоолой засварчин	1.2
6	241113	Ерөнхий нягтлан бодогч	2.1	16	221111	Их эмч, ерөнхий мэргэжлийн	1.1
7	833213	Жолооч, ачааны тэрэгний	1.9	17	832213	Жолооч, бага оврын, бүхээгт тэрэгний	1.1
8	222111	Сувилагч, ерөнхий мэргэжлийн	1.6	18	741111	Цахилгаанчин	1.1
9	541411	Харуул, гэрээт албаны	1.6	19	721214	Гагнуурчин	1.1
10	513111	Зөөгч	1.4	20	712611	Сантехникч, хоолой угсрагч	1.1

Ажиллах хүчний эрэлтийн хүрээнд дээд боловсрол шаардах мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээний хувьд ерөнхий нягтлан бодогч, цахилгааны инженер, ерөнхий мэргэжлийн их эмч, сувилагч зэрэг ажил мэргэжил харьцангуй эрэлттэй байх төлөвтэй байна. Эдгээр ажил мэргэжлийн эрэлт өмнөх жилийн ажил мэргэжлээрх эрэлтэд ч багагүй хувийг эзэлж байжээ.

Судалгааны үр дүнгээр 2020 онд эрэлттэй байх ажил мэргэжлийн чиглэлээр зуучилж болох бүртгэлтэй ажилгүй иргэний мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сангаас тодруулан үзлээ.

Хүснэгт 2.16. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хувь, эрэлттэй ажил мэргэжлээр

ISCO код	Эрэлттэй ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь
931211	Туслах ажилтан, барилгын туслах	1.8
932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	0.1
524212	Борлуулагч	0.007
911214	Цэвэрлэгч, албан байгууллагын	0.6
343412	Тогооч, ерөнхий	3.3
241113	Ерөнхий нягтлан бодогч	2.9
833213	Жолооч, ачааны тэрэгний	0.2
222111	Сувилагч, ерөнхий мэргэжлийн	0.2
541411	Харуул, гэрээт албаны	0.1
513111	Зөөгч	0.1
215111	Инженер, цахилгааны	0.08
833215	Жолооч, хогны машины	0.01
751111	Мах махан бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан	0.1
523011	Дэлгүүрийн кассчин	0.1
712612	Сантехникч, хоолой засварчин	0.3
221111	Их эмч, ерөнхий мэргэжлийн	0.2
832213	Жолооч, бага оврын, бүхээгт тэрэгний	0.01
741111	Цахилгаанчин	0.8
721214	Гагнуурчин	1.2
712611	Сантехникч, хоолой угсрагч	0.4

Эх сурвалж: ХХҮЕГ

2020 оны жилийн эцсийн байдлаарх бүртгэлтэй ажилгүй иргэдийн 3.3 хувь нь тогооч, 2.9 хувь нягтлан бодогч, 1.8 хувь нь барилгын туслах ажилтан зэрэг ажил мэргэжлийн чиглэл бүхий иргэд байна. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн зэх зээлийн эрэлтэд нийцэхүйц мэргэжилтэй ажиллах хүчин хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй байна.

Энэхүү судалгааны хүрээнд ажил олгогчид ажиллах хүч шалгаруулж, хүний нөөцөө бүрдүүлэхдээ мэргэжлийн болон харилцаа хандлагын хувьд нэн тэргүүнд шаарддаг, чухалчилж харгалзан үзэх ур чадварын талаар асууж тодрууллаа. Ажил олгогчид ажил мэргэжлийн ур чадвар гэхээс илүүтэй хувь хүний үндсэн зан чанарт суурилсан ур чадварыг чухалчилдаг хэвээр байна. Өөрөөр хэлбэл хувь хүний зан чанар, суурь хүмүүжил, ерөнхий хандлага, ес зүйг хамгийн чухал үзүүлэлт буюу чухал ач холбогдолтой хэмээн үзжээ.

Зураг 2.14. Ажил олгогчдын чухалчилдаг ур чадварын шаардлага

/Ач холбогдлын зэргээр, 1- огт чухал биш, 2-чухал биш, 3-чухал, 4-маш чухал/



Ач холбогдлоор нь харвал ажил олгогчид шинэ ажилтан авахдаа ажил горилогчийн найдвартай, хариуцлагатай байдал, ажлын ёс зүйг хамгийн ихээр чухалчилж байгаа нь өмнөх жилийн судалгааны үр дүнтэй ижил байна. Мөн харилцааны ур чадвар, багаар ажиллах чадвар, эерэг зөв хандлагатай, цаг ашиглалт сайтай байх нь ажил олгогчдод чухал ач холбогдолтой, нэн тэргүүнд шаардах ур чадвар байсаар байна. Түүнчлэн ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдлэг, үүнтэй холбоотой чадвар нь онцгойлон үзэх ур чадвар мөн тул ажил олгогчид чухал ач холбогдолтой ур чадварын нэгээр нэрлэсэн байна. Харин гадаад хэлний мэдлэг, шинжлэх ухаан технологийн мэдлэг, математик сэтгэлгээ, задлан шинжлэх чадварыг шинэ ажилтнаасаа төдийлөн шаардахгүй гэжээ. Энэхүү хандлага жил бүрийн судалгаанд давтамжтайгаар ажиглагдаж буй бөгөөд ажил олгогчид зөв харилцаа, төлөвшилтэй ажилтанд ажил мэргэжлийн ур чадварыг практик дадлагаар болон сургалтаар хөгжүүлэх бүрэн боломжтой гэж үзсээр байна. Үүнийг ажиллах хүчний эрэлттэй байх хоёр аж ахуйн нэгж тутмын нэг нь “шинэ ажилтнаа өөрийн хөрөнгөөр сургана” гэсэн мэдээллээс харж болно.

Ажил олгогчдын зүгээс шаардаж буй ур чадварын шалгуур, шаардлагыг судалгааны асуулгад өгөгдсөн дээрх үзүүлэлтүүдийн хүрээнд тодорхойлохоос гадна шаардлагатай ажиллах хүчний хувьд ажил мэргэжил бүрээр тодруулсан бөгөөд энэ үзүүлэлтийг эрэлттэй 20 ажил мэргэжлийн хүрээнд харвал ажил мэргэжлийн онцлогоос үл хамааран “ажлын туршлагатай байх” гэсэн шаардлагыг эрэлттэй байх ажил мэргэжил бүрт гол шалгуураа болгосон байна.

Барилгын болон үйлдвэрлэл аж ахуйн туслах ажилтанд тавьж буй гол шаардлага нь ажлын туршлагатай байх явдал гэсэн бол үйлдвэрлэл аж ахуйн чиглэлээс хамаарч тухайн чиглэлийн сургууль төгссөн бол давуу талтай гэжээ. Харин зөөгч, цахилгаанчин, сантехникч, хоолой угсрагч гэх ажил мэргэжлийн хувьд ажил олгогчид мэргэжлийн үнэмлэхтэй байхыг шаардаж байгаа бол


жолооч, тогооч, гагнуурчин зэрэг ажил мэргэжлийн хувьд үүнээс гадна ангиллын үнэмлэх, мэргэжлийн зэрэгтэй байх шаардлага ихэвчлэн тавьжээ. Ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалан нягтлан бодогч мэргэжлийн хувьд санхүүгийн программ хангамж дээр ажиллаж чаддаг, их эмчийн хувьд нарийн мэргэжил /гэмтэл согогын, дотрын, хүүхдийн, мэдрэлийн, гоо сайхны г.м/ эзэмшсэн байх гэсэн шалгуурыг голчлон тавьжээ. Харин борлуулагч ажил мэргэжлийн хувьд ихэнх тохиолдолд жолооны үнэмлэхтэй байхыг илүүд үзсэн бол зарим тохиолдолд марктенгийн чиглэлээр их дээд сургууль төгссөн байх нь давуу талтай гэжээ.

Сургалт, арга хэмжээ

Энэ онд ажиллах хүчний эрэлттэй байх аж ахуйн нэгж байгууллагуудаас шинэ ажиллагчдаа сургах талаар тодруулсан бөгөөд тэдний 51.9 хувь нь өөрийн хөрөнгөөр сургаж, дадлагажуулна гэжээ.

Сүүлийн 12 сарын хугацаанд ажил олгогчдын 33.9 хувь нь байгууллага дотооддоо сургалт зохион байгуулах, гадаад болон дотоодын сургалт, арга хэмжээнд хамруулах замаар ажиллагчдынхаа мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажилласан байна. Тухайлбал сургалтын төрлөөр харвал нийт зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт арга хэмжээний 49.2 хувь нь ажилтныг ажил мэргэжлийн хувьд мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалт байгаа бол 22.2 хувь нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, 22.3 хувь нь хувь хүний хөгжилд чиглэсэн сургалт арга хэмжээ эзэлж байна.

Зураг 2.15. Ажиллагчдад чиглэсэн сургалт, арга хэмжээ, хувиар



Ажил олгогчдын цаашдын төлөвлөгөө

Судалгааны хүрээнд ажил олгогчдоос үйл ажиллагааны ойрын хугацааны төсөөлөл, байгууллагын цаашдын төлөвлөгөөний талаар асууж тодруулдаг. Ажил олгогчдын 16.0 хувь нь ойрын 3 жилд үйл ажиллагаагаа өргөтгөж, хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөөтэй байна. Харин 40.8 хувь нь хөрөнгө оруулалт оруулах төлөвлөгөө байхгүй бол 43.3 хувь нь энэ талаар төсөөлөл байхгүй буюу мэдэхгүй гэжээ.

Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбар, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарын ажил олгогчид ирэх 3 жилд үйл ажиллагаагаа илүү өргөтгөх, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна. Ирэх 3 жилд эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал тогтвортой байж, ажил олгогчдын төлөвлөгөө бодит байдалд биеллээ олох тохиолдолд шинээр ажлын байр бий болж, 50 гаруй мянган ажиллах хүчний хэрэгцээ бий болох тооцоо гарсан нь тэр хэмжээгээр дотоодын хөдөлмөрийн зах зээл тэлэх боломж, нөхцөл бүрдэх эерэг дур зураг төсөөлөгдөж байна. Үүнд дээрх гурван салбар голлох нөлөө үзүүлэхээр харагдаж байна. Томоохон ажил олгогчдын хувьд стратеги төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын хэмжээ, түүний хүрээнд бий болох ажиллах хүчнийг урьдчилсан байдлаар тооцоолсон байгаа бол жижиг, дунд аж ахуйн нэгжийн хувьд тодорхой бус байгааг дурьдах нь зүйтэй юм.

Хөрөнгө оруулалтын хэмжээг сонирхож үзвэл 2021 онд нэг аж ахуйн нэгжийн хувьд дунджаар 90.0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт төлөвлөсөн бол энэ нь томоохон ажил олгогчдын хувьд 190.0 сая, жижиг ажил олгогчдын хувьд 60 гаруй сая төгрөг байх төсөөлөл байна.

Харин ойрын 3 жилд тэтгэвэрт гарах иргэдийн мэдээллийг тодруулахад 2020 онд 9.0 мянган ажиллагчид, 2021 болон 2022, 2023 онд тус бүр 4.0-5.0 мянган ажиллагчид тэтгэвэрт гарах төлөвтэй байна.

Ажил олгогчдод зөвхөн ажиллах хүчний эрэлт бий болохоос гадна нөгөө талаар ажиллагчдаа цомхотгох асуудал байхыг үгүйсгэж болохгүй бөгөөд энэ талаар тодруулахад ажил олгогчдын маш бага хэсэг буюу зөвхөн 0.6 хувь нь ажиллагчдаа цомхотгоно гэжээ. Өөрөөр хэлбэл аж ахуйн нэгжийн 99.4 хувь нь цомхотгол хийх төлөвлөгөөгүй гэсэн эерэг үр дүн харагдаж байна. Хэдийгээр ажиллагчдаа цомхотгох төлөвлөгөө бүхий ААНБ бага байгаа хэдий ч цомхотголын хүрээнд 0.6 мянган ажиллагчид ажлаас халагдах төлөвтэй байна.


Цомхотгол хийх шалтгааныг тодруулбал 40.2 хувийг хөрөнгө санхүүгийн хомсдолтой холбоотой хүндрэл, 35.6 хувийг үйл ажиллагаа зогсонги байдалд орсон гэсэн шалтгаан зонхилж байгаа нь ажиллагчдаа цомхотгох шалтгааны 75.8 хувийг бүрдүүлж байна.

2.3. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХОМСДОЛ

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгааны нэг зорилт нь судалгаа явагдсан нэг жилийн хугацааны хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний хомсдолыг илрүүлэх явдал бөгөөд эдийн засгийн салбар ба бүсүүдэд хэрхэн тархаж буйг тодорхойлдог.

Өнгөрсөн онд аж ахуйн нэгж байгууллагын 18.5 хувь нь зохих мэргэжилтэй ажиллагч олдоогүйн улмаас авахаар төлөвлөсөн ажилтнаа авч чадаагүй буюу ажиллах хүчний хомсдолд өртсөн байна. Ажиллах хүчний хомсдолыг эх олонлогт тархааж үзвэл жилийн хугацаанд 17.7 мянган ажиллах хүчний хомсдол үүссэн бөгөөд энэ нь өмнөх оны /2018/ дүнгээс 2.7 хувиар буурсан байна.

Зураг 2.16. Зохих мэргэжилтэй ажилтан олдоогүйгээс ажилтан авч чадаагүй байдал, бүсээр, хувиар



Ажиллах хүчний хомсдолтой байсан ААНБ-ыг байршлаар харвал Улаанбаатар хотын ажил олгогчдын 21.1 хувь нь ажиллах хүчний хомсдолд өртсөн ба эдгээр ААНБ-ын хүрээнд 13.2 мянган ажлын байр сул байсан нь нийт хомсдолтой ажиллах хүчний 74.8 хувийг эзэлж байна.

Төвийн бүсийн ажил олгогчдын 18.1 хувь нь, Баруун бүсийн ажил олгогчдын 7.5 хувь, Зүүн бүсийн ажил олгогчдын 5.2 хувь ажиллах хүчний хомсдолд өртсөн бол Хангайн бүсийн ажил

олгогчдын 16.7 хувь нь ажиллах хүчний хомсдолд өртжээ. Хангайн бүс болон Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын ажиллах хүчний хомсдолд өртсөн хувь өмнөх оны судалгааны дүнгээс өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд энэ хэмжээгээр бүрэн хүчин чадлаар ажиллах боломжоо алдсан байна.

Өнгөрсөн жилийн хугацаанд улсын хэмжээнд үүссэн ажиллах хүчний хомсдолын 25.2 хувь буюу 4.5 мянга нь орон нутгийн хэмжээнд байжээ. Төвийн бүсэд нийт ажиллах хүчний хомсдолын 9.4 хувь буюу 1.7 мянга, Баруун бүсэд 3.6 хувь буюу 0.6 мянга, Зүүн бүсэд 0.9 хувь буюу 0.2 мянган ажиллах хүчний хомсдол байсан нь өмнөх оны судалгааны дүнгээс буурсан үзүүлэлт юм. Харин Хангайн бүсэд ажиллах хүчний хомсдол 2.1 мянга хүрч өссөн нь ажиллах хүчний улсын хэмжээнд дэх хомсдолын 11.7 хувь, орон нутгийн ажиллах хүчний хомсдолын 46.3 хувийг дангаараа эзэлж байна.

Хүснэгт 2.17. Ажиллах хүчний хомсдол, бүсээр, хүйсээр

Бүс	Хомсдолтой ажиллах хүчний тоо /мян.хүн/		Дүнд эзлэх хувь	
	Нийт	Үүнээс: эмэгтэй	Нийт	Үүнээс: эмэгтэй
Баруун	0.6	0.2	3.3	2.2
Хангай	2.1	1.4	11.7	15.1
Төв	1.7	1.0	9.4	11.4
Зүүн	0.2	0.1	0.9	0.6
Улаанбаатар	13.2	6.4	74.8	70.7
Нийт	17.7	9.1	100.0	100.0

Өнгөрсөн хугацаанд ААНБ-уудад дутагдсан 17.7 мянган ажлын байрны 9.1 мянга буюу 51.4 хувь нь эмэгтэй ажилтны хомсдол байжээ.

Ажиллах хүчний хомсдолд өртсөн нийт ААНБ-уудын 25.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд ажиллах хүчний хомсдолын 24.4 хувийг тухайн салбарын хомсдол эзэлж байна. Энэ нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд энэ хандлага сүүлийн 5 жилд давтагдаж байгаа үзүүлэлт юм. Үүнээс гадна боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарын ажил олгогчид ажиллах хүчний хомсдолд өртсөн аж ахуйн нэгжүүдийн 19.9 хувийг эзэлж, эдгээр салбарын ажиллах хүчний хомсдол нийт хомсдолын 25.1 хувийг бүрдүүлж байна. Үүнээс үзэхэд өнгөрсөн жил зөвхөн дээрх гурван салбарт ажиллах хүчний хомсдолоос үүдэлтэй 8.8 мянган сул ажлын байр байжээ. Харин ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, цахилгаан, хий агааржуулалтын салбарын ажил олгогчид ажиллах хүчний хомсдолд бага өртсөн нь өмнөх жилийн үр дүнг давтаж байна. Энэ нь эдгээр салбарт ажиллах хүчний эрэлт бага гардаг, нөгөө талаас тухайн салбарын мэргэжлүүд нь салбар хооронд шилжих боломж хязгаарлагдмал байдагтай холбон тайлбарлаж болох юм.

Хүснэгт 2.18. Ажиллах хүчний хомсдол, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажиллах хүчний хомсдол		Үүнээс: эмэгтэй	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.5	2.8	0.2	2.4
Уул уурхай, олборлолт	0.3	2.0	0.0	0.3
Боловсруулах үйлдвэрлэл	2.3	13.1	1.2	12.8
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.1	0.3	0.0	0.0
Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.0	0.3	0.0	0.1
Барилга	2.1	11.9	0.4	3.9
Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	4.3	24.4	2.8	30.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.7	3.8	0.1	0.8
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1.3	7.2	1.0	10.6
Мэдээлэл, холбоо	0.4	2.5	0.1	1.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0.2	1.2	0.1	0.8
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.3	1.8	0.2	2.1
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.8	4.3	0.2	2.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.7	3.8	0.2	2.7
Боловсрол	0.9	5.2	0.7	7.9
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1.5	8.4	1.2	13.7
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0.2	1.3	0.1	1.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.0	5.6	0.6	6.7
Нийт	17.7	100.0	9.1	100.0

Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарын ажиллах хүчний хомсдолын 83.6 хувь, боловсролын салбарын 77.3 хувь, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарын ажиллах хүчний хомсдолын 74.8 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарын ажиллах хүчний хомсдолын 64.8 хувь нь эмэгтэй ажиллагчдын хэрэгцээ байжээ.

Зураг 2.17. Ажиллах хүчний хомсдол, байгууллагын өмчийн хэлбэрээр, мянган хүнээр



Өнгөрсөн жилийн хугацаанд хувийн өмчийн ААНБ-ууд ажиллах хүчний хомсдолд хамгийн их өртсөн бөгөөд нийт хомсдолтой ажиллах хүчний 88.5 хувь болох 15.6 мянган ажилтан авч ажиллуулж чадаагүй байна. Үүний 50.0 хувь нь эмэгтэй ажиллагчдын хэрэгцээ байжээ.

Ажиллах хүчний хомсдолыг ажил мэргэжлийн үндсэн бүлгээр авч үзвэл “Мэргэжилтэн” буюу II бүлэгт хамаарах ажил мэргэжлийн ажилтны хомсдол 31.0 хувь, “Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан” буюу VII бүлгийн ажил мэргэжлийн ажилтны хомсдол 18.1 хувь, “Худалдаа, үйлчилгээний ажилтан” буюу V бүлгийн ажил мэргэжлийн ажилтны

хомсдол 15.4 хувь, “Энгийн ажил мэргэжил” бүлгийн ажилтны хомсдол 15.4 хувийг тус тус эзэлж байгаа нь хамгийн өндөр буюу нийт ажиллах хүчний хомсдолын 79.9 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 2.19. Ажиллах хүчний хомсдол, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгээр, хувиар

Үндсэн бүлгийн дугаар	Ажил мэргэжлийн ангилал	Дүнд эзлэх хувь
1	Менежер	1.7
2	Мэргэжилтэн	31.0
3	Техникч болон туслах/дэд мэргэжилтэн	8.9
4	Контор үйлчилгээний ажилтан	2.7
5	Худалдаа, үйлчилгээний ажилтан	15.4
6	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	1.1
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	18.1
8	Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	5.7
9	Энгийн ажил мэргэжил	15.4
	НИЙТ	100.0

Ажиллах хүчний хомсдолыг ажил мэргэжлээр тодруулан хамгийн их хомсдолтой байсан эхний 20 ажил мэргэжлийг авч үзвэл худалдагч, үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан, борлуулагч, харуул, гал тогооны туслах ажилтан, албан байгууллагын үйлчлэгч, зам индүүдлэгийн ажилтан гэх мэт энгийн ажил мэргэжлийн, мөн зөөгч, оёдолчин, нарийн мужаан, тогооч, гагнуурчин, бармен зэрэг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэдэг ажиллах хүчин болон бага энгийн багш, сувилагч, нягтлан бодогч, эм зүйч ажил мэргэжлийн ажиллах хүчний хомсдол тус тус өндөр байжээ. Эдгээр ажил мэргэжлийн ажиллах хүчин хомсдолтой байснаас шалтгаалан 2020 оны ажиллах хүчний эрэлтэд ч багагүй хувийг эзэлж байна

Хүснэгт 2.20. Хомсдолтой ажил мэргэжил, дүнд эзлэх хувиар

Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь	Д/д	ISCO код	Ажил мэргэжлийн нэр	Дүнд эзлэх хувь
1	521111	Мухлаг худалдагч /лангууны	3.8	11	752222	Нарийн мужаан	1.8
2	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	3.3	12	931311	Туслах ажилтан, барилга угсралтын	1.6
3	911214	Цэвэрлэгч, албан байгууллагын	3.3	13	513211	Бармен	1.6
4	513111	Зөөгч	2.7	14	321313	Эм найруулагч	1.5
5	222111	Сувилагч, ерөнхий мэргэжлийн	2.7	15	524212	Борлуулагч	1.5
6	226215	Эмийн сангийн эм зүйч /эмийн худалдааны/	2.1	16	234111	Багш, бага энгийн /мэргэжлийн/	1.4
7	343412	Тогооч, ерөнхий	2.0	17	941212	Гал тогооны туслах ажилтан	1.4
8	541411	Харуул, гэрээт албаны	1.9	18	241113	Ерөнхий нягтлан бодогч	1.3
9	753311	Оёдолчин, эдлэлийн зөөлөн	1.9	19	711413	Зам индүүдлэгийн ажилтан	1.3
10	721214	Гагнуурчин	1.9	20	721515	Кабельчин	1.2

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд, хувийн хөдөлмөрийн биржүүдээр дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд бүртгүүлсэн ажлын байрны захиалгын мэдээллийг харахад ч дээрх ерөнхий дүр зураг харагдаж байна. Тодруулбал, тус мэдээллийн санд 2019 онд 70.0 гаруй мянган ажлын байр нээлттэй зарлагдаж, мэдээллийн санд бүртгүүлсэн бөгөөд нийт ажлын байрны захиалгын 2.0 хувь нь тогооч, 3.6 хувь нь жолооч 0.8 хувь нь оёдолчин, 0.9 хувь нь нягтлан бодогч гэсэн ажил мэргэжлийн ажиллах хүчний захиалга эзэлж байжээ.

Дээрх мэдээллүүдийг нэгтгэн авч үзвэл тодорхой хэдэн ажил мэргэжлийн хүрээнд ажиллах хүчний хөдөлгөөн хөдөлмөрийн зах зээлд нөлөөлөхүйц их, үүнтэй холбоотой тухайн ажил мэргэжлийн ажиллагчид хэрэгцээтэй болон хомсдолтой ажиллах хүчний жагсаалтад аль алинд нь байнга дурдагдаж, өндөр хувийг эзэлсээр байгааг харж болно. Энэ нь анхаарал хандуулахуйц мэдээлэл болж байна.

2.4. АЖИЛ ОЛГОГЧДОД ШИНЭ АЖИЛТАН АВАХАД ТУЛГАРДАГ БЭРХШЭЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

Судалгаагаар ажиллах хүчний эрэлт, хомсдолыг тодорхойлохын зэрэгцээ аж ахуйн нэгж, байгууллагын шинээр ажилтан авахад ашигладаг мэдээллийн эх сурвалж, шинэ ажилтан сонгон шалгаруулж авах, ажиллуулахад тулгардаг хүндрэл бэрхшээл зэрэг асуудлын талаар тодруулан судалдаг.

Ажил олгогчдын шинэ ажилтан авахдаа ашигладаг мэдээллийн эх сурвалж

Судалгааны дүнгээр цахим орчин, мэдээллийн хэрэгслээр нийтлэх байдлаар ажилтнаа сонгон шалгаруулж, хүний нөөцөө бүрдүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагууд зонхилж байна. Шинэ ажилтан авахад ашигласан мэдээллийн эх сурвалжийн 55.0 хувийг дээрх төрлийн эх сурвалж эзэлж байна. Энэ нь интернет, цахим хэрэглээ хөгжих тусам дагаад цаашид ч өргөн хэрэглэгдэх эх сурвалж болж байна. Түүнчлэн, албан бус байдлаар буюу хувийн харилцаа, холбоогоор, ажил хайгч иргэд өөрөө ажил олгогчид хандан ажилд орох, сургууль, сургалтын байгууллагаар дамжуулан ажиллах хүчнээ сонгох нь хөдөлмөрийн зах зээлд элбэг хэвээр байгаа ба энэ удаагийн судалгаагаар ашиглаж буй мэдээллийн эх сурвалжийн 32.0 хувийг эзэлж байна. Харин хөдөлмөр зуучлалын төрийн үйлчилгээ буюу хөдөлмөр, халамжийн хэлтсүүдийн мэдээллийг ашигладаг байдал 6.0 хувь байгаа бөгөөд орон нутгийн ажил олгогчдын хувьд эсрэгээрээ дээрх үйлчилгээг түлхүү ашигладаг байна. Мөн орон нутагт иргэд өөрсдөө ажил хайж, ажил олгогчид шууд хандах үзэгдэл өндөр хэвээр байна.

Зураг 2.18. Шинэ ажилтан авахад ашигладаг мэдээллийн эх сурвалж, хувиар



Нийслэлд интернет цахим мэдээлийг ашиглахаас гадна хувийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, ажлын байрны яармагаас ажиллах хүчний хэрэгцээт мэдээллийг ихэвчлэн авдаг байна.

Шинэ ажилтан авахад тулгардаг бэрхшээл

Энэ удаагийн судалгааны дүнгээр хамгийн түгээмэл тохиолддог бэрхшээлд ажил горилогчийн ажлын туршлагагүй байдал, тогтвортой ажиллах хүсэлгүй байгааг дурдсан бөгөөд энэ нь өмнөх жилийн судалгааны дүнд мөн нэрлэгдэж байжээ.

Ажил олгогчдын нэрлэсэн үзүүлэлтийн 16.4 хувийг ажилтан авахад хүндрэл бэрхшээл учирдаггүй гэсэн хариулт эзэлж байгаа бол 18.8 хувийг ажиллагч тогтвортой ажиллах хүсэлгүй байх, 15.0 хувийг тухайн ажил хайгчийн ажлын туршлагагүй байдал, 14.5 хувийг ажлын ачаалал даах чадваргүй байдал, 13.9 хувийг ажлын байрны нөхцөл, цалин хөлс голдог гэсэн бэрхшээлүүд эзэлж байгаа нь нийт бэрхшээлийн 62.2 хувийг бүрдүүлж байна.

Шинээр ажилтан авахад тулгарч буй гол бэрхшээл нь дээр дурдсанчлан ажил горилогчийн хувь хүний төлөвшил, хандлага, хариуцлагатай холбоотой асуудлууд байсаар байна.

Зураг 2.19. Шинээр ажилтан авахад болон ажиллуулахад тулгардаг нийтлэг бэрхшээл, хувиар



Харин ажил горилогчийн нас, хүйс болон гадаад төрх, бие бялдрын хөгжилтэй холбоотой асуудал хамгийн бага хувийг эзэлж байгаа бөгөөд ажил олгогчид эдгээр асуудлыг хүндрэл бэрхшээл гэж үзэхгүй байгааг харж болно.

2.5. ӨМНӨХ СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Хөдөлмөрийн зэх зээлийн эрэлтийн барометрийн судалгааг бид 10 дах жилдээ гүйцэтгэж байгаа бөгөөд энэ хэсэгт судалгааны гол үр дүнг өмнөх судалгаануудтай харьцуулан авч үзлээ.


Жил бүрийн судалгааны түүвэрт 50-аас доош ажиллагчидтай ААНБ-ын эзлэх хувь хамгийн өндөр байдаг бөгөөд энэ жилийн судалгааны хувьд ч ажил олгогчдын 60 гаруй хувийг эзэлж байна. Мөн 100-149 хүртэлх ажиллагчидтай ААНБ 19.1 хувь, 150-аас дээш ажиллагчидтай ААНБ 5.5 хувийг бүрдүүлж байна.

Улс орны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан хөдөлмөрийн зах зээлийн агшилт, тэлэлт явагдаж байдаг. Гэвч ажиллах хүчний эрэлтийн ерөнхий чиг хандлага, ажил олгогчдын төлөвлөгөөг харвал дотоодын хөдөлмөрийн зах зээл цаашид тэлэх, хөгжих бүрэн боломж байгааг харж болно.

Жил бүрийн судалгааны дүнгээс хөдөлмөрийн зах зээлд улирлаас хамаарсан нөлөөлөл ажиглагддаг бөгөөд энэ нөлөө тус судалгааны үр дүнгээр тооцоологдсон ажиллах хүчний эрэлтэд ч харагдаж байна. Тухайлбал, нэг жилийн ажиллах хүчний эрэлтийн 3 ажлын байр тутмын 2 нь оны эхний хагас жилд бий болох хандлагатай байдгийг жил бүрийн судалгааны үр дүнгээс харж болно.

Улсын хэмжээнд ажиллах хүчний эрэлт 57.6 мянгаас 80.1 мянгын хооронд хэлбэлзэж байсан бол 10 жилийн дундаж нь 72.2 мянга бөгөөд 2017 онд 70.7 мянга, 2019 онд 69.4 мянга болж буурч байжээ. Энэ жилийн буюу 2020 оны ажиллах хүчний эрэлт сүүлийн 5 жилийн хугацаан дахь дундаж үзүүлэлт болж байгаа ч өнгөрсөн жилээс 4.8 хувиар өсөх дүн гарлаа.

Зураг 2.20. Ажиллах хүчний эрэлт, мянган хүнээр, 2011-2020 он



Жил бүрийн судалгаагаар эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллын хувьд бөөний болон жижиглэн худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудад ажиллах хүчний эрэлтийн хэмжээ өндөр байж, ажиллах хүчний эрэлтийн ихэнх хувийг бүрдүүлдэг хэдий ч, жил бүр хэлбэлзлэлтэй байдаг хэвээр байна. Өмнөх жилтэй харьцуулахад барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын эрэлт буурч, бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээний салбарын ажиллах хүчний эрэлт өсөх төлөвтэй байна.

Зураг 2.21. Ажиллах хүчний эрэлт, тэргүүлэх салбараар, мянган хүнээр



Хөдөө аж ахуйн салбарын ажиллах хүчний эрэлт сүүлийн 3 жилийн турш буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд 2020 оны хувьд өмнөх оноос өсөх үр дүн гарлаа.

Сүүлийн 6 жилийн дүнгээр боловсруулах үйлдвэрлэлийн салбарын ажиллах хүчний эрэлт 8.9-10.3 мянгад хүрч өсөх үр дүн гарсан ч 2018 оны хувьд өмнөх жилээс буурч байсан бол энэ жилийн тухайд ч өмнөх жилээс буурсан үзүүлэлтийг давтсан үр дүн гарлаа. Харин бөөний болон жижиглэн худалдааны салбарын нөхцөл байдал нэлээд тогтворгүй байгаа бөгөөд 2016 он хүртэл өсөх хандлагатай байсан хэдий ч 2017 онд буурч, сүүлийн 6 жил дэх хамгийн бага байх үр дүнг харуулж байжээ. Харин энэ удаагийн судалгааны дүнгээр өмнөх оноос 26.5 хувиар өсөх төлөв гарлаа.

Зураг 2.22. Ажиллах хүчний эрэлт, бүс нутгаар, мянган хүнээр



Ажиллах хүчний эрэлтийн ихэнх хувийг Улаанбаатар болон Төвийн бүсийн ажиллах хүчний эрэлт бүрдүүлдэг бөгөөд нийт эрэлтийн 70-аас дээш хувийг эзэлдэг. Зарим жилүүдэд эдгээр байршилд бий болох эрэлт ажиллах хүчний эрэлтийн 90 гаруй хувийг бүрдүүлж байсан тохиолдол байна. Улаанбаатар хотын хөдөлмөрийн зах зээлийн багтаамж 2017 оныг хүртэл агшиж, дараагийн 2 жилийн байдлаар тэлэх дүр зураг харагдаж байсан бол энэ оны хувьд буурах хандлага ажиглагдаж байна. Харин Төвийн бүсийн хөдөлмөрийн зах зээл 2017 оныг хүртэл өсөх чиг хандлагатай байсан ч дараагийн 2 жилд буурах үр дүн гарсан бол энэ жилд өсөх төлөвтэй байна. Хангай болон Баруун бүсийн хөдөлмөрийн зах зээлийн багтаамж 4 жил дараалан буурсан дүр зурагтай байсан бол 2020 онд өсөх үр дүн харагдаж байна.

Жил бүрийн ажиллах хүчний эрэлтэд улирлын нөлөө байсаар байна. Сүүлийн 8 жилийн дунджаар ажиллах хүчний эрэлтийн 65-аас дээш хувь нь тухайн оны эхний 6 сард бий болохоор харагдаж байна. Сүүлийн жилүүдэд энэ хандлага өсөх дүр зурагтай бөгөөд 2020 онд ажиллах хүчний эрэлтийн 80 гаруй хувь нь оны эхний хагаст хамаарагдаж байна.

Зураг 2.23. Ажиллах хүчний эрэлт, хугацаагаар, хувиар




Судалгааны жил бүрийн үр дүнгээс байнгын ажлын байран дахь ажиллах хүчний эрэлт өндөр байдаг бөгөөд энэ нь хөдөлмөрийн зах зээлд нэн таатай үзэгдэл юм. Сүүлийн 4 жилийн судалгааны дүнгээр нийт ажиллах хүчний эрэлтийн 70-аас дээш хувь нь байнгын ажлын байр байна. Энэ үзүүлэлт жил ирэх бүрт өсөх хандлагатай бөгөөд 2020 оны хувьд ажиллах хүчний эрэлтийн хүрээн дэх нийт ажлын байрны 80 гаруй хувийг бүрдүүлж байна.

Зураг 2.24. Ажиллах хүчний эрэлт, ажлын байрны хэлбэрээр, хувиар



Судалгаагаар ажиллах хүчний эрэлтийг ажлын байрны төрлөөр авч үзэх үзүүлэлтийг 2014 оноос тооцож эхэлсэн бөгөөд үүнээс хойших 7 жилийн дунджаар ажиллах хүчний эрэлт бий болж буй ажлын байрны 50 гаруй хувь нь шинээр бий болох ажлын байр байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчний цэвэр өсөлт бий болох боломжийг илтгэх бөгөөд дотоодын хөдөлмөрийн зах зээл тэр хэмжээгээр тэлэх бололцоог бий болгох юм. Энэ ч үүднээс шинэ ажлын байрны мэдээлэл судалгааны үр дүнгийн чухал мэдээллийн нэг болдог.

Зураг 2.25. Ажиллах хүчний эрэлт, ажлын байрны төрлөөр, хувиар



Шинэ ажлын байрны ажиллах хүчний эрэлт 2014 онд нийт эрэлтийн 37.0 хувийг бүрдүүлж байсан бол 2018 онд хамгийн их буюу 65.3 хувийг эзэлж байжээ. 2020 оны хувьд ажиллах хүчний эрэлтийн 59.8 хувийг эзлэх үр дүн гарсан.

Бид энэхүү судалгааны үр дүнд тулгуурлан хөдөлмөрийн зах зээлийн богино хугацаанд эрэлттэй байгаа ажил мэргэжлийг мөн харьцуулан харах боломж бүрддэг.

Хүснэгт 2.21. Эрэлттэй ажил мэргэжил, оноор

2020 оны эрэлттэй ажил мэргэжил		2019 оны эрэлттэй ажил мэргэжил	
ISCO	Ажил мэргэжлийн нэр	ISCO	Ажил мэргэжлийн нэр
931211	Туслах ажилтан, барилгын туслах	712311	Засалчин, шаварчин
932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан
524212	Борлуулагч	931211	Барилга угсралтын туслах ажилтан
911214	Цэвэрлэгч, албан байгууллагын	753311	Оёдолчин
343412	Тогооч, ерөнхий	832211	Жолооч
241113	Ерөнхий нягтлан бодогч	711511	Барилгын мужаан
833213	Жолооч, ачааны тэрэгний	711411	Арматурчин
222111	Сувилагч, ерөнхий мэргэжлийн	541412	Хамгаалагч
541411	Харуул, гэрээт албаны	741111	Цахилгаанчин
513111	Зөөгч	833213	Ачааны машины жолооч
215111	Инженер, цахилгааны	431216	Санхүүгийн ажилтан
833215	Жолооч, хогны машины	214438	Механикч инженер
751111	Мах махан бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан	753118	Эсгүүрчин
523011	Дэлгүүрийн кассчин	343411	Тогооч
712612	Сантехникч, хоолой засварчин	241113	Нягтлан бодогч
221111	Их эмч, ерөнхий мэргэжлийн	522112	Хүнсний барааны худалдаалагч
832213	Жолооч, бага оврын, бүхээгт тэрэгний	524212	Борлуулагч
741111	Цахилгаанчин	311513	Техникийн туслах ажилтан
721214	Гагнуурчин	214524	Хүнсний технологич
712611	Сантехникч, хоолой угсрагч	541411	Харуул

Ажиллах хүчний эрэлтийг ажил мэргэжлийн ангиллаар харахад манай улсын хөдөлмөрийн зах зээлд хэд хэдэн нийтлэг төлөв байдал ажиглагддаг бөгөөд энэ жилийн хувьд ч энэ төлөв давтагдлаа. Үүнд:


- ✓ Ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлгийн “мэргэжилтэн” буюу II бүлэг, “энгийн ажил мэргэжил” буюу IX бүлгийн ажил мэргэжлүүд эрэлтийн ихэнх хувийг бүрдүүлдэг.
- ✓ Жил бүрийн судалгааны үр дүнгээр энгийн ажил мэргэжлүүд нэлээд эрэлттэй байсаар байна. Тухайлбал, үйлчилгээний ажилтан, үйлчлэгч, барилга, үйлдвэрлэл аж ахуйн туслах ажилтан гэх мэт. Мөн нягтлан бодогч, авто машины жолооч, тогооч, зөөгч, хамгаалагч зэрэг ажил мэргэжил эрэлттэй байдаг бөгөөд эдгээр ажил мэргэжил нь эдийн засгийн салбар бүрд хэрэгцээтэй байдагтай шууд холбоотой юм.
- ✓ Ажиллах хүчний ажил мэргэжлээрх эрэлтэд өндөр хувийг эзэлж буй мэргэжлийн ажиллах хүчин нөгөө талаас хомсдолтой ажиллах хүчний жагсаалтад багагүй хувийг эзэлдэг байдал олон жилийн судалгааны үр дүнд хадгалагдсаар байна. Мөн ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнд оролцогчдод тухайн ажил мэргэжлийн ажиллах хүчин онцгойлон анхаарал татахуйц байр суурь эзэлж байна.
- ✓ Хөдөлмөрийн зах зээлд дээд боловсролын ажил мэргэжлийн эрэлтээс илүү мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэгддэг ажил мэргэжлийн эрэлт өндөр байх хандлага олон жилийн судалгаагаар илэрхийлэгддэг.

Судалгааны үр дүнгээр тодорхой хэдэн ажил мэргэжлийн ажиллах хүчний эрэлт жил бүрийн ажиллах хүчний эрэлтэд өндөр хувийг эзэлсэн хэвээр байгаа нь анхаарал татсаар байна. Тухайлбал, барилга угсралтын туслах ажилтан, хамгаалагч, цэвэрлэгч зэрэг энгийн ажил мэргэжил, барилгын засалчин, шаварчин, арматурчин, цахилгаанчин зэрэг барилгын салбарын ажил мэргэжил, оёдолчин, тогооч, жолооч, борлуулагч зэрэг мэргэжлийн боловсрол сургалтын тогтолцоогоор бэлтгэдэг ажил мэргэжлүүд сүүлийн 8 жил дараалан хамгийн их эрэлттэй байхаар тодорхойлогдсон байна. Энэхүү өндөр эрэлтийн шалтгаан олон янз бөгөөд томоохон шалтгааны нэг бол дээр дурдсанчлан эдийн засгийн салбар бүрд байдаг хэрэгцээнээс гадна тухайн ажлын байран дахь ажиллагчдын шилжих хөдөлгөөнтэй шууд холбоотой юм.

Харин дээд боловсрол шаардагдах ажил мэргэжлүүдээс нягтлан бодогч, их эмч, сувилагчийн эрэлт, хэрэгцээ өндөр буюу жил бүрийн эрэлттэй ажил мэргэжлийн нэгээр нэрлэгдсэн хэвээр байна. Мөн ажиллах хүчний хомсдолд дээрх ажил мэргэжил тус бүрийн хомсдол багагүй хувийг эзэлдэг бөгөөд сүүлийн 6 жилд энэ үр дүн давтагдлаа.

Ажиллах хүчний хомсдол 2015 онд хамгийн их 19.5 мянга байсан бөгөөд үүнээс хойш буурах хандлагатай байсан бөгөөд 2017 онд 10.9 мянга болсон нь хамгийн бага түвшин байв. Харин 2018 оны хувьд өмнөх жилээс өсөж, 18.2 мянгад хүрсэн бол 2019 онд 17.7 мянга болж буурчээ.

Зураг 2.26. Ажиллах хүчний хомсдол, мянган хүнээр, 2013-2020 он



Ажиллах хүчний хомсдолыг ажил мэргэжлээр харахад их эмч, сувилагч, нягтлан бодогч, арматурчин, тогооч, жолооч, сантехникч зэрэг ажил мэргэжлийн ажиллах хүч жил бүр хомсдолтой байсаар байна.

Хүснэгт 2.22. Хомсдолтой ажил мэргэжил, оноор

2019 оны ажиллах хүчний хомсдол		2018 оны ажиллах хүчний хомсдол	
ISCO	Ажил мэргэжлийн нэр	ISCO	Ажил мэргэжлийн нэр
521111	Мухлаг /лангууны худалдагч	712311	Засалчин, шаварчин
932912	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	221114	Их эмч
911214	Цэвэрлэгч, албан байгууллагын	343412	Тогооч
513111	Зөөгч	931211	Барилгын туслах ажилтан
222111	Сувилагч, ерөнхий мэргэжлийн	752221	Модон бүтээгдэхүүний мужаан
226215	Эмийн сангийн эм зүйч /эмийн худалдааны/	832211	Жолооч
343412	Тогооч, ерөнхий	712612	Сантехникч
541411	Харуул, гэрээт албаны	522311	Худалдагч
753311	Оёдолчин, зөөлөн эдлэлийн	753311	Оёдолчин
721214	Гагнуурчин	711411	Арматурчин
752222	Нарийн мужаан	214440	Хөргөлтийн инженер
931311	Туслах ажилтан, барилга угсралтын	711511	Барилгын мужаан
513211	Бармен	721214	Гагнуурчин
321313	Эм найруулагч	911214	Албан байгууллагын үйлчлэгч
524212	Борлуулагч	932912	Үйлдвэрийн ажилтан
234111	Багш, бага ангийн /мэргэжлийн/	524212	Борлуулагч
941212	Гал тогооны туслах ажилтан	523011	Кассчин
241113	Ерөнхий нягтлан бодогч	241113	Нягтлан бодогч
711413	Зам индүүдлэгийн ажилтан	214524	Хүнсний технологич
721515	Кабельчин	515312	Жижүүр

ДУГНЭЛТ

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн ажиллах хүчний 2020 оны эрэлтийг эдийн засгийн 18 салбарын хүрээнд тодорхойллоо. Энэ онд хөдөлмөрийн зах зээлд 72.7 мянган ажиллах хүчний эрэлт үүсэх төлөвтэй байна. Үүний 81.6 хувь нь оны эхний хагаст, үлдсэн 18.4 хувь нь сүүлийн хагас жилд бий болох хандлагатай байна.

Ажиллах хүчний нийт эрэлтийн 22.9 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, 20.0 хувь нь барилгын салбарт, 10.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 6.1 хувь нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 5.5 хувь нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар, 5.0 хувь нь хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбаруудад тус тус бий болохоор байна.

Нийт ажиллах хүчний эрэлтийн 81.3 хувь нь байнгын, 18.7 хувь нь түр ажиллах хүчний эрэлт, 59.8 хувь нь шинэ, 40.2 хувь нь сул ажлын байрны эрэлт байна. Түр ажиллах хүчний эрэлтэд барилгын салбарын ажиллах хүчний эрэлт голлон нөлөөлж буйг түр ажиллах хүчний эрэлтийн 41.2 хувийг дангаараа бүрдүүлж байгаагаас харж болно.

Улс орны эдийн засгийн нөхцөл байдал, аж ахуйн нэгж байгууллагын бизнесийн өсөлт нь шинэ ажлын байрны нийлүүлэлтэд шууд нөлөөлж байгаа бол ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлтийн тогтворгүй байдал зэрэг нь сул ажлын байрны орон зай үүсэхэд нөлөөлсөн гол хүчин зүйлс болсон хэвээр байна.

Ажил олгогчид ажил хайгчийн ажлын туршлага, хувь хүний ажлын хариуцлага, хандлага, эерэг зан чанар зэрэг зөөлөн ур чадварыг илүүд үзэж байгаа хандлага түгээмэл хэвээр байна. Эдгээр зан чанарын зөв төлөвшил бүхий ажил хайгчийн мэргэжлийн ур чадварыг практик, давтан сургалтаар эзэмшүүлэх боломжтой хэмээн үздэг байна.

Энгийн ажил мэргэжлийн ажиллах хүчний эрэлт жил бүр өндөр байсаар байна.

Ажил мэргэжлээрх ажиллах хүчний эрэлт болон ажиллах хүчний хомсдолын мэдээлэл бусад ажил мэргэжлээр тооцдог үр дүнгүүдээс харахад хэд хэдэн төрлийн ажил мэргэжлийн ажиллах хүчин аль ч үзүүлэлтэд байнга нэрлэгдэж, энэ үр дүн сүүлийн жилүүдэд давтагдаж байгаа нь онцгойлон анхаарал татаж байна. Үүнээс үүдэн тухайн ажил мэргэжлийн ажиллах хүчний нийлүүлэлтэд анхаарах, шилжилт хөдөлгөөний учир шалтгааныг тодорхойлох шаардлага үүсч байна.

Өнгөрсөн онд аж ахуйн нэгж байгууллагуудад нийт 17.7 мянган ажиллах хүчний хомсдол бий болжээ. Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар үзвэл бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклын засвар үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, барилга, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбаруудад хамгийн их хомсдол үүссэн ба ажиллах хүчний нийт хомсдолын 65.1 хувь нь ногдож байна.

Ажил олгогчид шинээр ажилтан авахдаа сонин, телевиз, интернэтийн зар мэдээллийг түлхүү ашигладаг байна. Хөдөлмөр зуучлалын төрийн болон хувийн үйлчилгээг ажил олгогчид ашиглан ажилтан авах нь Улаанбаатар хотод харьцангуй илүү байна. Энэ төрлийн үйлчилгээний хэрэглээ зөвхөн нийслэлд түгээмэл байна.

Шинээр ажилтан авахад тулгарч буй гол бэрхшээл нь ажил горилогчийн ажлын туршлага байгаа хэдий ч хувь хүний төлөвшил, харилцаа хандлага, тогтвор суурьшилтай, хариуцлагатай холбоотой асуудлууд байсаар байна. Эдгээр хүндрэл бэрхшээл жил бүрийн судалгаагаар удаа дараа нэрлэгдсээр байгаа юм.

САНАЛ , ЗӨВЛӨМЖ

Бид энэхүү судалгааны дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргэж байна.

- ✓ *Жил бүр хөдөлмөрийн зах зээлд шинэ ажлын байрны эрэлт өсөж байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн хүрээ нэмэгдэх боломж байгааг харуулж байна.*
- ✓ *Жил бүр эрэлттэй байхаар тодорхойлогддог, ойрын ирээдүйд эрэлт өсөж буй ажил мэргэжлийн нийлүүлэлтэд анхааран, хөдөлмөр эрхлэлтийн бодлого, шийдвэрийг чиглүүлэх шаардлага байсаар байна.*
- ✓ *Хөдөлмөрийн нөөц дэх томоохон бүлэг болох бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой, мэргэжилгүй, ажлын туршлагагүй залуу ажиллах хүчинд чиглэсэн бодитой бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгцээ өндөр байна.*
- ✓ *Төрийн болон хувийн хөдөлмөр зуучлалын байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг ажилгүй иргэдийн тархалтай уялдуулан сайжруулах, ажлын байрны зуучлалын үйл ажиллагааны олон талт хэлбэрийг сонгох, үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах. Хөдөлмөр эрхлэлт, зуучлалын төвийн үйл ажиллагааг олон нийтэд, тэр дундаа залуусын дунд байнга сурталчлах. Мөн тухайн жилийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт өндөртэй эдийн засгийн салбарын ААНБ-тай нягт хамтран ажиллах, харилцааг өргөжүүлэх хэрэгцээ байна.*
- ✓ *Ажил олгогчдын хүсч буй зөөлөн ур чадварыг ЕБС, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтаар эзэмшүүлэх, төлөвшүүлэхэд анхаарах, мөн хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлбэл зохино.*
- ✓ *Ажиллагчдад шаардагдаж буй мэргэжлийн болон зөөлөн ур чадварын талаар нарийвчлан судлах, бүх шатны сургалтын хөтөлбөрт тусгах асуудлыг анхаарах хэрэгтэй.*
- ✓ *Ажлын байранд зуучлагдсан иргэдийг байгууллагын шинэ соёлд дасан зохицох, тогтвортой, суурьшилтай ажиллахад нөлөөлөх зорилго бүхий зуучлалын дараах 5 хоног дахь давтан сургалтын модулийг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага өнгөрсөн жилийн судалгаанд дурдагсны адил байсаар байна.*

Техникийн тэмдэглэл

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ

1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Үндэслэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны талаар баримталж буй төрийн бодлого, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг оновчтой болгох үүднээс хөдөлмөрийн зэх зээлийн эрэлт, нийлүүлэлтийн талаар суурь судалгааг тогтмол хийдэг бөгөөд энэ үүднээс хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны эрэлтийг тодорхойлох ээлжит судалгааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт хийж гүйцэтгэлээ.

Зорилго

Хөдөлмөрийн зах зээлийн богино хугацаа /2020 он/-ы ажиллах хүчний эрэлтийг ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тодорхойлж, боловсрол сургалтын, хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид болон судлаачдыг мэдээллээр хангахад оршино.

Зорилт

Үндсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- 2020 оны ажиллах хүчний эрэлт хэрэгцээг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, ажил мэргэжил, байршил тус бүрээр тодорхойлох;
- Дотоодын хөдөлмөрийн зах зээлд өнгөрсөн нэг жилийн хугацаанд үүссэн ажиллах хүчний хомсдолыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлээр тодорхойлох;
- Жил бүрийн судалгааны үр дүнгээр динамик мэдээлэл бэлтгэж, ХЗЗ-ийн эрэлтийн хандлагыг тодорхойлох.

Судалгааны хязгаарлагдмал байдал

Судалгаа дараах хязгаарлалтыг өөртөө агуулсан болно. Үүнд:

1. Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоог ашигласан учраас албан бус секторын хөдөлмөрийн эрэлт тодорхойлогдоогүй;
2. 2019 онд шинээр үйл ажиллагаа эрхэлж эхэлсэн аж ахуйн нэгж байгууллагууд түүврийн хүрээнд багтаагүй;
3. Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбар, төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн хамгааллын салбаруудыг түүврийн хүрээнээс хасаж тооцсон.

Судалгааны ерөнхий зохион байгуулалт

Судалгааны мэдээллийг ААНБ-ын удирдлага, удирдах албан тушаалтантай уулзаж, ярилцлагын аргаар цуглууллаа. Мэдээлэл цуглуулахад судалгааны баг дараах зарчмыг баримтлан ажилласан. Үүнд:

- ✓ Шинжлэх ухааны үндэслэлтэй, нэгдсэн арга зүйг ашиглах;
- ✓ Судалгаанд оролцогчдын мэдээллийн нууцлалыг хамгаалах;
- ✓ Бүх ойлголт, тодорхойлолт нь оролцогч талуудад /тухайлбал, асуулга боловсруулагчид, ярилцлага авагчид, судалгаанд оролцогчид, мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажилтнууд/ ойлгомжтой байх;
- ✓ Цуглуулсан мэдээлэл нь судалгааны зорилгод нийцсэн, үнэн бодитой байх;
- ✓ Судалгааны дүн, тайлан нь тодорхой, ойлгомжтой, хэрэгцээтэй байх.

Судалгааны мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг 2019 оны 8 дугаар сарын 13-аас 12 дугаар сарын 13-ны өдрүүдэд зохион байгуулж, Үндэсний статистикийн хорооны Бизнес регистрийн санд бүртгэлтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ААНБ-аас түүвэрлэн хамруулсан.

Энэ удаагийн судалгаанд Дэлхийн банкны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн дэмжлэг, туслалцаатайгаар судалгааны түүврийн хэмжээг нэмэгдүүлэн 3813 ААНБ болгосон.

2. СУДАЛГААНЫ ТҮҮВЭР, ХАМРАХ ХҮРЭЭ

Судалгаанд хамрагдах боломжтой нийт ААНБ-ын түүврийн эх олонлогийг 2018 оны жилийн эцэст Үндэсний статистикийн хорооны Бизнес регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоогоор тодорхойлсон. Идэвхтэй үйл ажиллагаа явуулсан буюу татварын байгууллага, Сангийн яаманд санхүүгийн тайлангаа өгөхдөө “үйл ажиллагаа явуулсан” гэж мэдүүлсэн, эдийн засгийн үйл ажиллагааны 18 салбарын аж ахуйн нэгжүүдийг хамруулан түүврийн хэмжээг тогтоосон.

Түүврийн хэмжээ:

Түүврийн хэмжээг тогтооход өмнөх судалгааны мэдээллийн баазад боловсруулалт хийж, үндсэн үр дүнг тооцоолохдоо түүврийн алдааны үзүүлэлтийг хамтад нь тооцож, үнэлсний үндсэнд тогтоосон. Энэ аргыг өмнөх жилүүдийн судалгаанд мөн хэрэглэсэн. Олон улсын жишигт давтамжтай хийгддэг судалгааны түүврийн дизайныг эхний удаад ижил төстэй судалгааны, давтан хийхдээ өмнөх судалгааны мэдээллийн баазаас түүврийн үнэлгээ хийх замаар тогтоодог. Өөрөөр хэлбэл, туршлагад үндэслэн таамагласнаас илүү бодит баримтад тулгуурлан таамаглах нь үр дүнтэй юм. ААНБ-ын үндсэн мэдээлэл, түүврийн дизайныг үнэлэхэд ажиллах хүч шинээр авах ААНБ-ыг тодорхойлоход ашигласан түүврийн олонлог, алдааны хязгаар, стандарт алдаан зэргээс харахад өнгөрсөн жилийн судалгааны үр дүн, төлөөлөх чадвар хангалттай байсныг харуулж байна.

Хүснэгт 1. Түүврийн хэмжээ, ажиллах хүчний хэрэгцээтэй ААНБ-ын эзлэх хувь, салбараар

ID	Салбарын нэр	Шинэ ажилтан авах ААНБ-ын эзлэх хувь	Стандарт алдаа	95% итгэх интервал		Вариацийн коэффициент	Алдааны хязгаар
				Доод	Дээд		
A	ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	32.3	1.4	29.4	35.2	0.0	2.9
B	Уул уурхай, олборлолт	30.1	1.9	26.3	34.0	0.1	3.8
C	Боловсруулах үйлдвэрлэл	38.0	1.0	36.0	40.0	0.0	2.0
D	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	29.8	3.3	23.2	36.5	0.1	*
E	Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	29.4	4.3	20.8	38.0	0.1	*
F	Барилга	46.0	0.9	44.2	47.8	0.0	1.8
G	Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	28.9	0.4	28.1	29.7	0.0	0.8
H	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	32.3	1.6	29.1	35.4	0.0	3.1
I	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	34.3	1.3	31.6	36.9	0.0	2.7
J	Мэдээлэл, холбоо	34.1	1.7	30.8	37.5	0.0	3.4
K	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	19.7	1.2	17.3	22.2	0.1	2.4
L	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	22.4	1.7	18.9	25.8	0.1	3.5
M	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	32.3	1.0	30.3	34.3	0.0	2.0

N	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	39.2	1.3	36.6	41.8	0.0	2.6
P	Боловсрол	26.7	0.8	25.1	28.4	0.0	1.7
Q	Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	44.8	1.1	42.5	47.1	0.0	2.3
R	Урлаг, үзвэр, тоглоом наадам	24.2	1.7	20.8	27.5	0.1	3.3
S	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	24.3	0.8	22.8	25.9	0.0	1.6

Эх сурвалж: ХНХСИ, ХЗЗБарометрийн судалгаа-2019, тооцоо хийсэн түүврийн хэмжээ 3642

Дээр дурдсан хосолмолын дагуу түүврийн хуваарилалтыг тооцсон бөгөөд ингэхдээ өмнөх судалгааны түүврийн дизайныг хэвээр хадгалах зарчмыг баримталсан болно. Ажиллагчдын тоо 150 ба түүнээс дээш байгаа 531 аж ахуйн нэгжийг нэлэнхүйд нь, 100 хувь судалгаанд хамруулахыг зорилоо. Уг судалгааны түүврийн хуваарилалт нь ААНБ-ын ажиллагчдын тоог бүлгийн хувьд харьцангуй хэвийн тархалттай гэж үзэн, Ньюманы хуваарилалтын аргаар зохиомжилж байсан юм.

Хүснэгт 2. Түүврийн хэмжээ, салбараар, ажиллагчдын тооны бүлгээр /мян/

ID	Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажиллагчдын тооны бүлэг					
		1-9	10-29	30-49	50-100	101-149	150- аас дээш
A	ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	74	73	33	13	5	2
B	Уул уурхай, олборлолт	12	21	32	33	76	11
C	Боловсруулах үйлдвэрлэл	44	86	63	59	82	16
D	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	7	13	15	8	22	9
E	Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	18	9	13	14	8	8
F	Барилга	28	55	63	52	121	12
G	Бөөний болон жижиглэн худалдаа: Машин мотоциклын засвар үйлчилгээ	89	62	35	21	115	8
H	Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	35	36	50	23	59	37
I	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	55	97	55	32	24	17
J	Мэдээлэл, холбоо	27	31	25	14	15	8
K	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	49	28	18	9	17	9
L	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	49	105	57	19	10	6
M	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	36	37	26	21	23	5
N	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	57	73	70	46	24	10
P	Боловсрол	15	34	82	60	61	28
Q	Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	25	62	53	16	53	10
R	Урлаг, үзвэр, тоглоом наадам	10	29	16	13	6	6
S	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	68	92	48	25	9	8
	Нийт	698	943	754	478	730	210

Хуваарилалтын явцад тухайн бүлэгт байгаа ААНБ-уудын тоо нь харьцангуй цөөн буюу төлөвлөсөн түүврийн хэмжээтэй хэтэрхий ойролцоо, эсвэл бага байгаа тохиолдолд тухайн бүлгийн ААНБ-уудыг нэлэнхүй гэж үзэж, бүгдийг судалгаанд хамруулсан. Энэ тохиолдолд тэдний төлөөлөх жин нь 1 болох юм. Түүврийн хүрээнээс судалгаанд хамруулах ААНБ-ыг сонгохдоо энгийн санамсаргүй түүврийн аргыг ашигласан болно.

3. СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, БОЛОВСРУУЛАЛТ

Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг компьютер ашиглан ярилцлага авах (CAPI) аргаар гүйцэтгэсэн. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг бэлтгэгдсэн мэдээлэл цуглуулагчид 21 аймаг, 9 дүүрэгт гүйцэтгэв. Судалгаанд 3642 ААНБ-ыг хамруулсан бөгөөд мэдээлэл цуглуулалтын хамрагдалтын түвшин 95.6 хувь болсон.

Судалгааны асуулга нь өмнөх жилүүдийн судалгааны үзүүлэлтээс гадна ажиллагчдын дэлгэрэнгүй мэдээлэл буюу ажил мэргэжлийн асуулт нэмэгдсэн бөгөөд дараах үндсэн 3 бүлэгтэй. Үүнд:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий мэдээлэл
2. 2020 оны ажиллах хүчний эрэлт, энэ оны ажиллах хүчний хомсдолын мэдээлэл
3. Хүний нөөц

Мэдээллийн чанарыг хангах зорилгоор явцын хяналтыг тогтмол явуулж, программд оруулсан мэдээллийг судалгааны ярилцлагын аудио бичлэгтэй тулгалт хийх, хариултын уялдаа холбоог шалган, шаардлагатай тохиолдолд судалгаанд оролцогчоос дахин тодруулга авч засварлан, баталгаажуулсан. Энэ удаагийн судалгаанд орон нутаг болон Улаанбаатар хотод хяналтын судалгааг зохион байгуулж, судалгааны мэдээлэл цуглуулалтын чанарын хяналтыг хийлээ.

Судалгааны мэдээллийг оруулахад CSPro 7.3 (тооллого, түүвэр судалгааны мэдээлэл боловсруулах систем) программыг, мэдээлэл боловсруулж, үндсэн үр дүнг нэгтгэн гаргахад Stata программыг ашигласан.

ХАВСРАЛТ

Хавсралт хүснэгт 0.1. Ажиллах хүчний эрэлт, салбар, мянган хүнээр, 2012-2020 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажиллах хүчний эрэлт								
	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	4.4	12.9	5.5	6.4	7.5	4.9	4.5	1.9	2.3
Уул уурхай, олборлолт	2.8	3.1	2.3	4.5	1.7	3.3	2.0	2.2	3.0
Боловсруулах үйлдвэрлэл	8.4	10.9	12.3	8.9	9.1	10.0	8.1	10.3	7.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж			0.7	0.2	1.7	1.2	0.3	0.5	0.7
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа				0.4	0.2	0.4	0.2	0.2	1.5
Барилга	9.1	14.8	22.4	17.0	11.4	9.8	18.6	17.7	14.5
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	14.1	14.3	12.6	19.1	24.5	5.5	15.2	13.2	16.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	4.0	7.0	2.6	2.0	2.3	3.2	2.8	2.8	2.0
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	2.6	3.6	2.7	2.6	2.6	5.7	3.1	3.8	4.0
Мэдээлэл, холбоо				1.9	1.2	2.2	1.9	1.6	1.6
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа			0.8	1.4	1.5	0.9	0.8	1.6	1.5
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				0.9	0.4	2.1	1.2	1.8	1.1
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа				3.6	2.7	2.0	4.8	2.5	2.5
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа				3.2	2.4	4.9	5.4	4.1	4.4
Боловсрол			0.5	1.0	2.8	5.5	2.3	1.7	2.8
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа			1.4	1.4	1.8	6.6	2.1	1.5	3.6
Урлаг, үзвэр, тоглоом наадам			0.0	0.4	1.9	1.5	0.6	1.2	0.9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	12.2	12.3	10.3	2.5	4.3	0.9	0.8	0.8	2.3
Нийт	57.6	78.8	75.4	77.5	80.1	70.7	74.6	69.4	72.7

Хавсралт хүснэгт 0.2. Эрэлттэй ажил мэргэжил, 2013-2020 он

Ажил мэргэжлийн нэр 2020	Ажил мэргэжлийн нэр 2019	Ажил мэргэжлийн нэр 2018	Ажил мэргэжлийн нэр 2017	Ажил мэргэжлийн нэр 2016	Ажил мэргэжлийн нэр 2015	Ажил мэргэжлийн нэр 2014	Ажил мэргэжлийн нэр 2013
Туслах ажилтан, барилгын туслах	Засалчин, шаварчин	Туслах ажилтан /барилгын/	Жолооч	Жолооч	Үйлдвэрийн туслах ажилтан	Туслах ажилтан /барилгын/	Борлуулагч
Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	Шаварчин, засалчин	Үйлчилгээний ажилтан	Хамгаалагч	Барилгын туслах ажилтан	Жолооч /ачааны тэрэгний/	Туслах ажилтан, барилга угсралтын
Борлуулагч	Барилга угсралтын туслах ажилтан	Хамгаалагч	Хамгаалагч	Барилгын туслах ажилтан	Тоног төхөөрөмжийн оператор	Үзүүлэн таниулж худалдаалагч	Тариаланч, ногоочин
Цэвэрлэгч, албан байгууллагын	Оёдолчин	Туслах ажилтан /үйлдвэрлэл, аж ахуйн/	Туслах ажилчин	Тогооч	Арматурчин	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан
Тогооч, ерөнхий	Жолооч	Туслах ажилтан /дэлгүүрийн/	Сувилагч	Үйлдвэрийн туслах ажилтан	Сувилагч	Шаварчин-засалчин, засал чимэглэлийн	Хамгаалалтын албаны ажилтан
Ерөнхий нягтлан бодогч	Барилгын мужаан	Борлуулагч	Технологич	Эмч	Жолооч	Тогооч	Жолооч /такси, бүхээгт тэрэг, ачааны том тэрэг/
Жолооч, ачааны тэрэгний	Арматурчин	Худалдагч	Барилгын мэргэжил өргөн	Сувилагч	Барилгын мужаан	Барилгачин	Тогооч
Сувилагч, ерөнхий мэргэжлийн	Хамгаалагч	Оёдолчин	Тогооч	Нягтлан бодогч	Барилгын дотоод засал	Харуул хамгаалалтын албаны ажилтан	Зөөгч
Харуул, гэрээт албаны	Цахилгаанчин	Цэвэрлэгч /албан байгууллагын/	Зөөгч	Бизнесийн удирдлага	Уул уурхайн туслах ажилтан	Сувилагч, ерөнхий мэргэжлийн	Хүнд даацын машин, том тэрэгний жолооч
Зөөгч	Ачааны машины жолооч	Тогооч	Их эмч	Санхүүгийн шинжээч	Хүнсний технологийн ажилтан	Дэлгүүрийн кассчин	Засалчин, шаварчин
Инженер, цахилгааны	Санхүүгийн ажилтан	Жолооч	Түгээгч	Ачигч	Сүлжигч	Цагдаа	Барилга угсралтын мужаан
Жолооч, хогны машины	Механикч инженер	Эм найруулагч	Үйлчлэгч	Багш	Ачигч агуулахын	Инженер, цахилгааны	Өрлөгчин, холбогдох бусад ажилтан
Мах махан бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан	Эсгүүрчин	Мужаан	Барилгын инженер	Үйлчлэгч	Оёдолчин	Зөөгч	Зам индүүдлэгийн ажилтан
Дэлгүүрийн кассчин	Тогооч	Нягтлан бодогч	Засварчин	Инженер	Өрлөгчин, шаварчин	Арматурчин	Арматурчин
Сантехникч, хоолой засварчин	Нягтлан бодогч	Инженер /иргэний барилгын/	Цахилгаанчин	Операторч	Баяжуулахын оператор	Зүсэгч, чулуу	Гагнуурчин
Их эмч, ерөнхий мэргэжлийн	Хүнсний барааны худалдаалагч	Өрөгч угсрагч	Борлуулагч	Барилгачин	Гагнуурчин	Цахилгаанчин	Худалдаачин /жижиглэнгийн газрын/
Жолооч, бага оврын, бүхээгт тэрэгний	Борлуулагч	Инженер /хийн хоолойн/	Нягтлан бодогч	Мужаан	Нягтлан бодогч	Ахлах нягтлан бодогч	Цахилгаанчин
Цахилгаанчин	Техникийн туслах ажилтан	Цахилгаанчин	Касс	Барилгын инженер	Тогооч	Теллер банкны	Борлуулалт, маркетингийн менежер
Гагнуурчин	Хүнсний технологич	Операторч /телефон холбооны/	Багш	Зөөгч бармен	Цэвэрлэгч, албан тасалгааны	Барилга угсралтын мужаан	Технологич, хүнс, ундааны
Сантехникч, хоолой угсрагч	Харуул	Угаагч үйлчлэгч	Галч	Сантехникч	Цахилгаанчин	Өрөгч, тоосгон гүүрний	Нягтлан бодогч

Хавсралт хүснэгт 0.3. Хомсдолтой ажил мэргэжил, 2014-2020 он

2019	2018	2017	2016	2015	2014
Ажил мэргэжлийн нэр					
Мухлаг /лангууны худалдагч	Засалчин, шаварчин	Худалдагч	Жолооч	Зөөгч	Сүлжигч
Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	Их эмч	Мужаан	Мужаан	Эмч	Барилгын туслах
Цэвэрлэгч, албан байгууллагын	Тогооч	Тогооч	Тогооч	Тогооч	Засалчин
Зөөгч	Барилгын туслах ажилтан	Жолооны багш	Байгаль хамгаалагч	Цахилгаанчин	Худалдагч
Сувилагч, ерөнхий мэргэжлийн	Модон бүтээгдэхүүний мужаан	Цэцэрлэгийн багш	Сүлжигч	Засал чимэглэл	Хүнсний технологич
Эмийн сангийн эм зүйч /эмийн худалдааны/	Жолооч	Эм найруулагч	Дуу хөгжмийн багш	Сантехникч	Мэдээллийн ажилтан
Тогооч, ерөнхий	Сантехникч	Нядлагч	Хамгаалалтын ажилтан	Мужаан	Бетон арматурчин
Харуул, гэрээт албаны	Худалдагч	Засалчин шаварчин	Цахилгаанчин	Гагнуурчин	Гагнуурчин
Оёдолчин, зөөлөн эдлэлийн	Оёдолчин	Тоног төхөөрөмжийн засварчин	Авто засварчин	Жолооч	Хамгаалагч
Гагнуурчин	Арматурчин	Оёдолчин	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэргэжилтэн	Үйлдвэрийн туслах ажилтан	Киттелчин
Мухлаг /лангууны худалдагч	Хөргөлтийн инженер	Хамгаалагч	Эмч	Сувилагч	Цутгагч
Үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан	Барилгын мужаан	Үсчин	Гагнуурчин	Механик инженер	Цахилгаанчин
Цэвэрлэгч, албан байгууллагын	Гагнуурчин	Хүнсний технологич	Дулааны инженер	Гадаад хэлний багш	Маркетинг борлуулалт
Нарийн мужаан	Албан байгууллагын үйлчлэгч	Арматурчин	Нэвтрүүлэгч	Барилгын туслах ажилтан	Сувилагч
Туслах ажилтан, барилга угсралтын	Үйлдвэрийн ажилтан	Кеттель машин баригч	Зөөгч	Өндрийн буулт хийгч	Авто замын инженер
Бармен	Борлуулагч	Зөөгч	Сантехник слесарь	Арматурчин	Худалдааны төлөөлөгч
Эм найруулагч	Кассчин	Хөдөө аж ахуйн механикжуулагч	Үйлчлэгч	Инженер	Үйлдвэрийн туслах ажилтан
Борлуулагч	Нягтлан бодогч	Сувилагч	Сувилагч	Нярайн сувилагч	Жолооч
Багш, бага ангийн /мэргэжлийн/	Хүнсний технологич	Үйлчлэгч	Соробан багш	Хүнсний ногоо тариалагч	Сантехникч
Гал тогооны туслах ажилтан	Жижүүр	Барилгын инженер	Нягтлан бодогч	Программ хангамжийн инженер	Шаварчин, өрлөгчин

**Хаяг: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт
Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо
Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөрийн ордон, 5 давхар
Утас: 77121286
Вэб хуудас: www.rilsp.gov.mn**